



2019 оны 03 дугаар сарын 06
№09/1062/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Компакт гэрээ соёрхон
батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

Журам батлах тухай

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Гадаад харилцааны ямаар
төлөөлүүлэн Монгол Улсын
Засгийн газар болон Мянганы
Сорилтын Корпорацаар
төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн
Улс хоорондын Мянганы
сорилтын компакт гэрээ**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

69. Компакт гэрээ соёрхон батлах тухай 297

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

70. Журам батлах тухай Дугаар 347 297

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

71. Гадаад харилцааны ямаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар болон Мянганы Сорилтын Корпорацаар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс хоорондын Мянганы сорилтын компакт гэрээ 305

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

КОМПАКТ ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гадаад харилцааны ямаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар, Мянганы Сорилтын Корпорацаар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Л.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 347

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.6, 22.9-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**



1. “Гамшгаас хамгаалах улсын алба, улсын албаны дарга, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт”-ыг 1 дүгээр, “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ыг 2 дугаар, “Гамшгаас хамгаалах улсын албаны удирдлага (штаб)-ын бүрэлдэхүүн”-ийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах улсын албадын гүйцэтгэх үүргийг тогтоож, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг улсын албаны дарга нарт, улсын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 97 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2018 оны 347 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБА, УЛСЫН АЛБАНЫ
ДАРГА, ТЭДГЭЭРИЙН ТҮШИГЛЭН АЖИЛЛАХ ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Улсын албаны нэр	Улсын албаны дарга	Түшиглэн ажиллах төрийн байгууллага
1.	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2.	Барилга, хот байгуулалтын алба	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3.	Зам, тээврийн алба	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



4.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн алба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.	Түлш, эрчим хүчний алба	Эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9.	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
10.	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга	Мэргэжлийн хяналтын төв байгууллага
11.	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн төв байгууллагын дарга	Цагдаагийн төв байгууллага
12.	Сурталчилгааны алба	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ
АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд гамшгаас хамгаалах улсын алба (цаашид “Улсын алба” гэх)-ны гүйцэтгэх нийтлэг чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, салбар хоорондын хамтын ажиллагааг хангахад энэ журмын зорилго оршино.

1.2. Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагыг түшиглэн Засгийн газрын тогтоолоор улсын албыг байгуулж, албаны даргыг томилно. Улсын албаны дарга нь салбарын сайд, төрийн захиргааны байгууллагын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга байна.

1.3. Улсын алба нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдлагын бүрэлдэхүүн (цаашид “штаб” гэх)-тэй байна.

1.4. Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын хүрээнд тухайн байгууллага Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж мөрдүүлнэ.

1.5. Улсын алба нь энэхүү нийтлэг журмын хүрээнд тухайн салбарын онцлогийг тусгасан журам боловсруулан мөрдөж болно.

1.6. Улсын алба нь Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын онцгой комиссын үйл ажиллагаатай уялдуулан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хоёр. Улсын албаны эрх, үүрэг

2.1. Улсын алба нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараахь үүрэгтэй:

2.1.1. улсын албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.1.2. шаардлагатай бол Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад албадтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;

2.1.3. гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;

2.1.4. гамшгаас хамгаалах чиглэлээр тушаал, албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, заавар боловсруулж батлах, хэрэгжүүлэх;



2.1.5. Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр шуурхай хангах;

2.1.6. гамшиг болон аюулт үзэгдэл, ослын үед салбарыг ажлын тусгай горим болон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;

2.1.7. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Гурав. Штабын эрх, үүрэг

3.1. Штаб нь дараахь эрх үүрэгтэй:

3.1.1. гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, улсын албаны даргаар батлуулах;

3.1.2. улсын албаны удирдлагын баримт бичгийг төлөвлөх, хүч хэрэгслийг томилж ажиллуулах;

3.1.3. гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлж, дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулах;

3.1.4. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын болон орон нутгийн албанаас гаргуулан авч, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.1.5. гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.6. орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;

3.1.7. гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага боловсруулах;

3.1.8. гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны



байгууллага холбогдох улсын болон орон нутгийн алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;

3.1.9. орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, гамшгаас хамгаалах чиглэлээр улсын албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх.

Дөрөв. Штабын бүрэлдэхүүн

4.1. Штаб нь дараахь бүрэлдэхүүнтэй байна:

4.1.1. штабын дарга-төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нэгжийн дарга, төрийн захиргааны байгууллагын даргын томилсон албан тушаалтан;

4.1.2. штабын орлогч-тухайн байгууллагын нэгжийн дарга;

4.1.3. гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагч-тухайн төрийн захиргааны байгууллагын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан;

4.1.4. холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан-тухайн төрийн байгууллагын мэдээлэл, холбооны асуудал хариуцсан нэгжийн дарга;

4.1.5. сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан-тухайн төрийн байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгжийн дарга;

4.1.6. санхүү, хангалт хариуцсан ажилтан-тухайн төрийн байгууллагын санхүү, хангалтын асуудал хариуцсан нэгжийн дарга;

4.1.7. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан-тухайн төрийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтан;

4.1.8. бусад ажилтан-салбарын болон гамшгийн нөхцөл байдал (нөлөөлөл, хамрах хүрээ, цаг хугацаа, болзошгүй хохирол, үр дагавар)-ын онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулж болно.

4.2. Штабын бүрэлдэхүүнийг тухайн салбарын бүтэц, зохион байгуулалттай нийцүүлэн өөрчилж болно.

4.3. Штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.

Тав. Сургалт, дадлага

5.1. Улсын албаны гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулна.

5.2. Сургалт, дадлагыг дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

5.2.1. улсын албаны удирдах албан тушаалтан, штабын бүрэлдэхүүний сургалт, дадлагыг 2 жилд нэг удаа;

5.2.2. мэргэжлийн ангийн сургалт, дадлагыг жил бүр;

5.2.3. үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдал, гамшгийн эрсдэл, давтамжийг харгалзан шаардлагатай сургалт, дадлагыг тухай бүр.

5.3. Улсын албад хоорондын хамтарсан сургалт, дадлагыг албадын дарга нарын хамтарсан шийдвэрээр зохион байгуулна.

5.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын албадын сургалт, дадлагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

5.5. Энэ журмын 5.2.1-т заасан сургалт, дадлагыг батлагдсан удирдамжийн хүрээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, 5.2.2, 5.2.3-т заасан сургалт, дадлагыг тухайн улсын алба, орон нутгийн Онцгой байдлын байгууллага хамтран зохион байгуулах бөгөөд холбогдох зардлыг тухайн улсын алба хариуцна.


Зургаа. Бусад

6.1. Улсын албаны томилгоот албан хаагчдад гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр, идэвх санаачлагыг нь үнэлж тухайн салбарын болон онцгой байдлын байгууллагын шагналаар шагнаж урамшуулж болно.

6.2. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчийн албан томилолтын зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоно.

6.3. Улсын албаны үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан удирдамжийн дагуу шалгаж, үнэлнэ.

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ УДИРДЛАГА (ШТАБ)-ЫН БҮРЭЛДЭХҮҮН



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН МЯНГАНЫ СОРИЛТЫН КОРПОРАЦААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС ХООРОНДЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН КОМПАКТ ГЭРЭЭ

МЯНГАНЫ СОРИЛТЫН КОМПАКТ ГЭРЭЭ

Энэхүү МЯНГАНЫ СОРИЛТЫН КОМПАКТ ГЭРЭЭ (энэхүү “Компакт гэрээ” гэх)-г Гадаад харилцааны яам (“Засгийн газар” гэх)-аар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар (“Монгол Улс” гэх) болон Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын байгууллага болох Мянган сорилтын корпорац (“МСК” гэх)-аар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс (тус бүртээ “Тал,” хамтдаа “Талууд” гэх)-ын хооронд байгуулав. Энэхүү Компакт гэрээнд том үсгээр эхлэн бичсэн нэр томъёо нь VI Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

УДИРТГАЛ ХЭСЭГ

Талууд Монгол Улсад эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах чиглэлээр ахиц дэвшил гаргаж, Талуудын хоорондын нягт хамтын ажиллагаа, түншлэлийг нотлон харуулсан Мянган сорилтын анхны Компакт гэрээг АНУ-ын Вашингтон хотноо 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулж, МСК-ын тулгуур бодлого, хэм хэмжээнд нийцүүлэн амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд уг Компакт гэрээ нь 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болж, 2013 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөр дуусгавар болсон болохыг эргэн санаж;

Талууд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах хамтын зорилгыг дэвшүүлж буйгаа, мөн энэхүү Компакт гэрээний хүрээнд МСК-аас үзүүлж буй тусламж нь сайн засаглалыг бэхжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөг хангах, хүний хөгжилд хөрөнгө оруулах Монгол Улсын эрмэлзлийг дэмжинэ гэдгийг хүлээн зөвшөөрч;

Засгийн газар МСК-ын тусламжийг ашиглах тэргүүлэх чиглэлүүдийг тогтоохдоо хувийн хэвшил болон иргэний нийгэмтэй зөвлөлдсөн бөгөөд тухайн тусламжийг ашиглан эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах санал боловсруулан МСК-д хүргүүлсэн болохыг эргэн санаж;

МСК нь энэхүү Компакт гэрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтуудад хүрэхийн тулд Компакт гэрээнд заасан хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр”



гэх бөгөөд Хөтөлбөрийн тайлбар, зорилтуудад Компакт гэрээнд заасан нөхцөлийн дагуу өөрчлөлт орох боломжтой)-ийг хэрэгжүүлэхэд Монгол Улсад туслах хүсэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрч;

Талууд дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Хэсэг. Компакт гэрээний зорилго.

Энэхүү Компакт гэрээний зорилго (“Компакт гэрээний зорилго” гэх) нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулахад оршино. МСК нь Монгол Улсад туслалцаа үзүүлэхдээ сайн засаглал, эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлэх, хүний хөгжилд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг зорьж байгаа болно.

1.2. Хэсэг. Төслийн зорилт.

Хөтөлбөр нь I Хавсралтад заасан төсөл (“Төсөл” гэх)-өөс бүрдэнэ. Энэхүү Төслийн зорилт (“Төслийн зорилт” гэх) нь Улаанбаатар хотын унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын тооцоолж буй усны эрэлтийг хангахад оршино.

2 ДУГААР ЗҮЙЛ САНХҮҮЖИЛТ, ЭХ ҮҮСВЭР

2.1. Хэсэг. Хөтөлбөрийн санхүүжилт.

Энэхүү Компакт гэрээний 7.3. дахь хэсэгт заасны дагуу Компакт гэрээ хүчин төгөлдөр болсоноор МСК нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж Засгийн газарт 321,940,000 (гурван зуун хорин нэгэн сая есөн зуун дөчин мянга) хүртэлх дүн бүхий ам.доллар (“Хөтөлбөрийн санхүүжилт” гэх)-ыг Компакт гэрээнд заасан нөхцөлийн дагуу олгоно. Компакт гэрээний хэрэгжилтийн хугацаанд Хөтөлбөрийн санхүүжилтийг хэрхэн хуваарилах талаар II Хавсралтад ерөнхий байдлаар харуулав.

2.2. Хэсэг. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт.

(а) Компакт гэрээнд гарын үсэг зурсанаар МСК нь Засгийн газарт энэхүү Компакт гэрээнд заасан нөхцөлийн дагуу, 2.1 дэх хэсэгт заасан Хөтөлбөрийн санхүүжилтээс гадна 28,060,000 (хорин найман сая жаран мянга)-аас илүүгүй дүн бүхий ам.доллар (“Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт” гэх)-ыг нэмэлт, өөрчлөлт оруулсан Мянганы сорилтын тухай

2003 оны хууль (“**Мянганы сорилтын тухай хууль**”)-ийн 609(г) дэх заалтын дагуу Компакт гэрээний хэрэгжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд дараах болон бусад зориулалтаар олгоно. Үүнд:

(i) Санхүүгийн менежментийн болон худалдан авах үйл ажиллагаа;

(ii) Захиргааны үйл ажиллагаа (Монголын Мянганы сорилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай, ажилтнуудын цалин зэрэг зардлыг оролцуулан) болон түрээсийн төлбөр, компьютер болон мэдээлэл, харилцаа холбооны бусад техник, технологи, эсхүл тоног төхөөрөмжийн хөрөнгийн зардал зэрэг захиргааны бусад зардал;

(iii) Мониторинг, үнэлгээний үйл ажиллагаа;

(iv) Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах болон төслийн бэлтгэлийг хангахад шаардлагатай судалгааны бусад ажил;

(v) Компакт гэрээний хэрэгжилтийн бэлтгэлийг хангахтай холбоотой МСК-ын зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа багтана.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хуваарилалтыг II Хавсралтад ерөнхий байдлаар харуулав.

(b) Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хөрөнгөөс зарцуулах тухай бүрт IV Хавсралтад заасан урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хангасан байна.

(c) Хэрэв МСК нь Компакт гэрээний 2.2(a) хэсэг дэх Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн нийт хэмжээ нь мөн хэсэгт заасан зориулалтын дагуу зарцуулахад шаардлагатай дүнгээс илүү гарсан гэж үзвэл Засгийн газарт бичгээр мэдэгдэж, тэрхүү илүүдэл дүн (“Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн илүүдэл дүн” гэх)-г эргүүлэн татаж болох бөгөөд энэ нь Компакт гэрээний 2.2(a) дахь хэсэгт заасан Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн хэмжээг бууруулна. Засгийн газарт ийнхүү бичгээр мэдэгдсэнээр Компакт гэрээний 2.2(a) дахь хэсэгт Засгийн газарт олгохоор заасан Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн дүн нь уг илүүдэл дүнгийн хэмжээгээр буурах бөгөөд МСК нь цаашид тэрхүү илүүдэл дүнтэй холбоотой аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй.

2.3. Хэсэг. МСК-ын санхүүжилт.

Хөтөлбөрийн санхүүжилт болон Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийг Компакт гэрээнд хамтад нь “МСК-ын санхүүжилт” гэх бөгөөд Хөтөлбөрийн санхүүжилт болон Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтэд Засгийн газраас Компакт гэрээний дагуу буцаан эсхүл нөхөн төлсөн аливаа хөрөнгийг оруулж тооцно.



2.4. Хэсэг. Зарцуулалт.

Энэхүү Компакт гэрээ болон Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээний дагуу, МСК нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлуудыг (тус бүрийг “Зарцуулалт” гэх) МСК-ын санхүүжилтээс гүйцэтгэхээр тогтов. Холбогдох бүх урьдчилсан болзолт нөхцөлийг хангасны дараа МСК нь санхүүжилтийг (а) Засгийн газраас нээж, МСК-ын зөвшөөрсөн нэг буюу хэд хэдэн банкны данс (тус бүр “Зөвшөөрөгдсөн данс” гэх)-нд тухайн хөрөнгийг байршуулах, эсхүл (б) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бараа, ажил, үйлчилгээг нийлүүлсэн этгээдэд төлбөрийг шууд гүйцэтгэх гэсэн хэлбэрийн аль нэгийг дангаараа сонгон хэрэгжүүлнэ. МСК-ын санхүүжилтийг зөвхөн Хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан зарцуулна.

2.5. Хэсэг. Хүү.

Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээний дагуу Засгийн газар нь МСК-ын санхүүжилтийг Хөтөлбөрийн зорилгын дагуу зарцуулж эхлэх хүртэлх хугацаанд хуримтлагдсан хүүгийн орлого болон аливаа бусад орлогыг МСК-д төлөх эсхүл шилжүүлнэ.

2.6. Хэсэг. Засгийн газрын эх үүсвэр болон төсөв.

(а) АНУ-ын Мянганы сорилтын тухай хуулийн 609(b)(2) дахь хэсэг болон МСК-ын Буцалтгүй тусламж хүлээн авах орны оруулах хувь хэмжээний тухай зааварчилгааны дагуу Засгийн газар нь 111,760,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун жаран мянган) ам.доллар, эсхүл дор заасны дагуу бууруулсан дүн бүхий хэмжээний хөрөнгийг Компакт гэрээгээр хэрэгжүүлэх Төслийн зорилтыг биелүүлэхэд зориулж Компакт гэрээ хэрэгжих хугацааны туршид хариуцан гаргана (“Засгийн газрын оруулах хувь хэмжээ” гэх). Энэхүү хувь хэмжээний зарцуулалтын хуваарилалтыг || Хавсралтад ерөнхий байдлаар тусгасан бөгөөд дэлгэрэнгүй хуваарийг Засгийн газрын оруулах хувь хэмжээтэй холбоотой нэмэлт нөхцөл, шаардлагын хамт Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд оруулна. Засгийн газрын оруулах хувь хэмжээ нь жил бүр Улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгах, нэгдсэн төсвийг хууль тогтоох байгууллагаар хэлэлцүүлэн батлуулах зэрэг Монгол Улсын төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад захирагдана. Засгийн газрын оруулах хувь хэмжээг МСК-аас зөвшөөрсний дагуу бууруулж болох бөгөөд ингэхдээ энэхүү өөрчлөлт нь (i) Төслийн зорилтыг үргэлжлүүлэн биелүүлэхэд зориулагдах бөгөөд (ii) Засгийн газрын оруулах хувь хэмжээг МСК-ын санхүүжилтийн 15 хувиас бага болгож бууруулахгүй байх ёстой. Үүний зэрэгцээ Засгийн газар нь Компакт гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай бусад бүхий л арга хэмжээг авах бөгөөд санхүүгийн болон бусад бүх эх үүсвэрийг гаргана.

(b) Хөтөлбөр хэрэгжих нийт хугацаанд санхүүгийн жил бүрт хүлээн авсан болон хүлээн авахаар төлөвлөсөн МСК-ын бүх санхүүжилтийг Засгийн газар тухайн жилийн Улсын нэгдсэн төсөвт бүрэн тусгуулахаар чармайн ажиллана.

(c) Засгийн газар нь Компакт гэрээ болон Хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаанд МСК-ын санхүүжилтээс бусад эх үүсвэрээс төсөвлөсөн болон хүлээн авахаар төлөвлөж буй хөрөнгө, санхүүжилтийг бууруулахгүй.

(d) Засгийн газраас бичгээр өөрөөр мэдэгдээгүй бол Компакт гэрээ болон Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаанд зарцуулах МСК-ын санхүүжилтийг эдгээр үйл ажиллагаанд зориулж Засгийн газар болон бусад эх үүсвэрээс хүлээн авахаар төлөвлөсөн санхүүжилт дээр нэмж тооцно.

2.7. Хэсэг. МСК-ын санхүүжилтийг ашиглахад тавигдах хязгаарлалт.

Засгийн газар нь МСК-ын санхүүжилтийг Компакт гэрээнд заасан эсхүл Засгийн газарт бичгээр мэдэгдсэний дагуу, АНУ-ын хууль, бодлогыг зөрчсөн дараах болон бусад зорилгоор ашиглахгүй гэдгийг зөвшөөрсөн болно. Үүнд:

(a) цэрэг, цагдаагийн албан хаагч, цэргийн бэлтгэл хүчин, үндэсний батлан хамгаалах хүчин болон хагас цэргийн зохион байгуулалттай байгууллага, нэгтгэлд тусламж үзүүлэх, эсхүл сургалт явуулах;

(b) АНУ-ын ажлын байрыг үлэмж хэмжээгээр бууруулах эсхүл АНУ-ын үйлдвэрлэлийг их хэмжээгээр шахан гаргахад хүргэж болзошгүй аливаа үйл ажиллагаа явуулах;

(c) МСК-ын Байгаль орчны зааварчилгаа болон энэхүү зааварчилгаатай холбогдуулан гарсан өөр бусад баримт бичиг (хамтад нь “МСК-ын Байгаль орчны зааварчилгаа” гэх)-т туссан, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ноцтой эрсдэл учруулж болохуйц аливаа үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэх буюу өөр бусад хэлбэрээр дэмжих;

(d) үр хөндөлтийг гэр бүл төлөвлөлтийн нэг арга хэрэгсэл болгон санхүүжүүлэх, үр хөндүүлэхийг албадах буюу хөхиүлэн дэмжих, өөрийн хүсэл зоригоос гадуур үргүйдүүлэх ажиллагааг гэр бүл төлөвлөлтийн нэг арга хэрэгсэл болгон санхүүжүүлэх, уг ажиллагааг албадах буюу санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эсхүл үр хөндөлт болон өөрийн хүсэл зоригоос гадуур үргүйдүүлэх ажиллагаа, түүнийг гүйцэтгэхтэй холбоотой эмнэлэг, биологийн бүрэн буюу хэсэгчилсэн судалгааг аливаа хэлбэрээр санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаа багтана.



2.8. Хэсэг. Татвар.

(a) Талууд бичгээр тусгайлан харилцан тохиролцоогүй бол Засгийн газар нь МСК-ын санхүүжилтийг Монгол Улсад (үндэсний, бүс нутгийн, орон нутгийн, төрийн бусад байгууллага, татварын газраас ногдуулах) одоо мөрдөж буй болон цаашид ногдуулж болзошгүй татвар, төлбөр хураамж, шимтгэл болон бусад ижил төстэй төлбөр (гэхдээ Монгол Улсад нийтлэг тохиолдох тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө ямар нэгэн ялгаварлалгүйгээр ногдуулдаг, үндэслэл бүхий хэмжээтэй хураамж, төлбөр үүнд орохгүй)-ийг (“Татвар”) төлөхөд ашиглахгүй байх нөхцөлийг хангана. Өмнө дурдсан Татварын ерөнхий төрлөөр үл хязгаарлагдан МСК-ын санхүүжилт нь тухайлан дараах татвар, төлбөр, хураамжаас чөлөөлөгдөнө. Үүнд: (i) Хөтөлбөртэй холбогдуулан Монгол Улсад нэвтрүүлэх бараа, хэрэгжүүлэх ажил, үйлчилгээнд ногдуулдаг аливаа тариф, гаалийн татвар, импортын болон экспортын татвар болон бусад төстэй татвар; (ii) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бараа, ажил, үйлчилгээнд ногдуулдаг худалдааны татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах татвар болон бусад төстэй татвар; (iii) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах хөрөнгө өмчлөх, эзэмших, эсхүл ашиглахтай холбоотой татвар болон төлбөр; (iv) Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж олсон орлого, ашигт ногдох татвар болон бусад ижил төстэй төлбөр хураамж, Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэсэн хувь хүн, хуулийн этгээдэд ноогдох нийгмийн даатгалын шимтгэл, бусад ижил төстэй төлбөр хамаарах бөгөөд энэ (iv) заалт нь (1) Монгол Улсын иргэн болон байнгын оршин суугч; (2) Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан бүртгэгдсэн хуулийн этгээд (үүнд Монголын МСС болон Компакт гэрээнд заасан Засгийн газрын үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан бусад хуулийн этгээд орохгүй)-эд үл хамаарна.

(b) Засгийн газрын 2.8(a) хэсэгт дурдсан татвараас чөлөөлөх заалтыг зарим үндсэн татваруудаас чөлөөлөхөд ашиглахаар зөвшөөрсөн зохицуулалтыг Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заана. Энэхүү зохицуулалт нь холбогдох хуулийн дагуу ногдуулсан татвараас чөлөөлөх, төлөгдсөн татварыг Засгийн газраас МСК, Монголын МСС, эсхүл татвар төлөгчид буцаах, эсхүл нөхөн төлөх, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд, 2.8(a) дахь хэсэгт заасан хэлбэрээр суутгасан татварыг Засгийн газраас МСК, эсхүл Монголын МСС-д төлөх гэсэн хэлбэртэй байж болно.

(c) Компакт гэрээний 2.8(a) дахь хэсэг, эсхүл Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заасан шаардлагыг үл харгалзан татвар төлөгдсөн тохиолдолд Засгийн газар нь МСК-д (эсхүл МСК-ын томилсон бусад этгээдэд) Талуудын харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу, тухайн татварыг төлсөн тухай Засгийн газарт (МСК, эсхүл Монголын МСС-гаас) бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 30 (гуч) хоногийн (эсхүл Талууд бичгээр

харилцан тохиролцсон бусад хугацааны) дотор ам.доллар, эсхүл монгол төгрөгөөр тооцон шуурхай буцаан олгоно. Заасан хугацаанд энэхүү дүнг эргүүлж төлөөгүй тохиолдолд 5.4. дэх хэсэгт заасны дагуу үлдэгдэл дүнд хүүг хуримтлуулан тооцно.

(d) Засгийн газар нь МСК-аас олгосон аливаа санхүүжилт, түүнээс олсон орлого, Хөтөлбөрийн өмч хөрөнгийг Компакт гэрээний 2.8(с) дэх хэсэгт заасан өөрийн үүргийг биелүүлэхэд ашиглахыг хориглоно.

2.9. Хэсэг. Бага дунд орлоготой орнууд.

АНУ-ын Мянганы сорилтын тухай хуульд “бага дунд орлоготой орнууд” гэх нэр томъёог оруулж, уг ангилалд Монгол Улсыг хамруулсан байдаг бөгөөд мөн хуулийн 606(b) дэх хэсэгт МСК-аас бага-дунд орлоготой орнуудад үзүүлэх тусламжийн хэмжээг хязгаарласан байдаг. МСК нь нягтлан үзэж, үндэслэлтэй хэмээн тогтоосны дагуу, Компакт гэрээгээр Засгийн газарт олгох Хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээ нь Мянганы сорилтын тухай хуулийн 606(b) дэх хэсэгт заасан хязгаараас давж болзошгүй тохиолдолд МСК нь Засгийн газарт бичгээр мэдэгдсэний дагуу өөрийн хүссэн үед, эсхүл тухай бүрт Хөтөлбөрийн санхүүжилтийг бууруулах, эсхүл зарцуулалтыг зогсоох эрхтэй.

3 ДУГААР ЗҮЙЛ ХЭРЭГЖИЛТ

3.1. Хэсэг. Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ.

Талууд хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах талаар болон санхүүгийн хариуцлага, МСК-ын санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалт зэрэг бусад асуудлыг нарийвчлан зохицуулсан гэрээ (“Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ” буюу ХХГ гэх) байгуулах бөгөөд Засгийн газар нь Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон аливаа бусад Нэмэлт гэрээ, Хэрэгжүүлэх захидалд заасны дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2. Хэсэг. Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлага.

(a) Засгийн газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үндсэн үүрэг хүлээнэ.

(b) МСК-аас бичгээр урьдчилан мэдэгдэж, зөвшөөрсний дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улмаар Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг ажилд хяналт тавих, Төсөл болон Төслийн хүрээнд хэрэгжих Үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх, эх үүсвэрийн зарцуулалтыг



төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой Засгийн газрын бусад эрх, үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын тогтоолоор үүсгэн байгуулна. Энэхүү этгээдийг “Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)” гэх бөгөөд Хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаатай холбогдуулан Засгийн газрыг төлөөлөх эрхтэй байна. Компакт гэрээгээр Монголын МСС-д аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эс хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэсэн аливаа заалт нь Засгийн газар Монголын МСС тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эс хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Засгийн газар нь Монголын МСС-г Талуудын 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн тухай хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавихтай холбоотой өөрийн эрх, үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх этгээдээр мөн томилж байгаа болно. Компакт гэрээний 3.2(b) дэх хэсгийн заалт нь Засгийн газрыг энэхүү Компакт гэрээний дагуу болон холбогдох бусад гэрээний дагуу хүлээх үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. МСК нь 3.2(b) хэсгийн заалт дахь томилгоог үүгээр хүлээн зөвшөөрөв.

(c) МСК-тай бичгээр өөрөөр тохиролцоогүй бол Засгийн газар нь МСК-ын санхүүжилтээр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь (шууд болон шууд бусаар) худалдан авсан Хөтөлбөрийн аливаа өмч хөрөнгө буюу санхүүжүүлсэн үйлчилгээг зөвхөн энэхүү Компакт гэрээ болон Хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан ашиглана.

(d) Засгийн газар нь Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Хөтөлбөрийн болон Төслийн зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай бөгөөд зохистой бүхий л (үүнд, МСК-тай бичгээр өөрөөр тохиролцоогүй бол 2.6(a) дахь хэсэгт зааснаар хязгаарлалгүйгээр, МСК-ын санхүүжилтээс хэтэрсэн, энэхүү Компакт гэрээнд заасан нөхцөл, зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай бүх зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ мөн орно) арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүгээр зөвшөөрөв.

(e) Засгийн газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах болон Компакт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ техник, санхүү, менежментийн зохих туршлагад тулгуурлан энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, аливаа Нэмэлт гэрээ, Хэрэгжүүлэх захидал болон Хөтөлбөрийн зааварчилгаа тус бүрт нийцүүлэн, хянамгай, үр бүтээлтэй, шаргуу хандаж ажиллахыг үүгээр зөвшөөрөв.

3.3. Хэсэг. Бодлогын хэрэгжилт.

Засгийн газар нь Компакт гэрээний 1 Хавсралтад тухайлан заасан бодлого, хууль эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ АНУ-ын Мянганы сорилтын тухай хуулийн 607 дахь хэсэгт заасан бодлогын

шалгуур үзүүлэлтүүд болон МСК-аас буцалтгүй тусламж үзүүлэх улсыг сонгон шалгаруулахдаа баримталдаг шалгуур үзүүлэлт, арга зүйн дагуу бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн түвшингээ хадгалах, цаашид сайжруулахаар ажиллахыг үүгээр зөвшөөрөв.

3.4. Хэсэг. Мэдээллийн үнэн зөв байдал.

Засгийн газар нь МСК-тай Компакт гэрээний талаар хэлэлцээ хийж, харилцан тохиролцоо явцад өөрөө болон өөрийн нэрийн өмнөөс МСК-д хүргүүлсэн аливаа мэдээлэл нь Компакт гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар үнэн зөв хийгээд бүрэн бүтэн болохыг МСК-д нотолж байна.

3.5. Хэсэг. Хэрэгжүүлэх захидал.

МСК нь Компакт гэрээ, МСК-ын санхүүжилт болон Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар Засгийн газарт бичгээр зааварчилгаа хүргүүлж болно. Засгийн газар тухайн зааварчилгааг Хөтөлбөрийн хэрэгжилтэд мөрдлөг болгоно. Талууд мөн Компакт гэрээний хэрэгжилт, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон холбогдох бусад гэрээтэй холбоотой асуудлаарх харилцан ойлголцлыг баталгаажуулах, баримтжуулах зорилгоор харилцан зөвшөөрсөн агуулга бүхий бичиг үйлдэж болно. Эдгээр бичгийг цаашид “Хэрэгжүүлэх захидал” гэнэ.

3.6. Хэсэг. Худалдан авах ажиллагаа болон Буцалтгүй тусламж

(а) Засгийн газар нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар болон аливаа бусад Нийлүүлэгчээс бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа (“МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа” гэх)-г баримтлахыг үүгээр зөвшөөрөв. Улмаар, Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд гүйцэтгэх худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж үйлчлэхгүй. МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа нь дараах болон бусад шаардлагыг агуулдаг. Үүнд:

(i) бараа, ажил үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулахаар зарлах, шалгаруулах ажиллагаа болон худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нээлттэй, шударга байдлыг хангаж, өрсөлдөөний зарчмыг ил тод хэрэгжүүлсэн байх;

(ii) бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа худалдан авах гэж буй бараа, ажил, үйлчилгээний ойлгомжтой, үнэн зөв тодорхойлолтод тулгуурласан байх;



(iii) худалдан авах гэрээг уг гэрээнд заасан нөхцөлүүдэд нийцүүлэн, гэрээнд заасан хугацаанд, үр ашигтайгаар биелүүлэх чадавх хийгээд эрмэлзэл бүхий, шаардлага хангасан оролцогчидтой байгуулах;

(iv) Зах зээлийн үнэтэй харьцуулах зэрэг аргыг ашиглан тогтоосон, зах зээл дээрх зохих түвшнээс илүү үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх зэрэг шаардлага багтана.

(b) МСК бичгээр өөрөөр зөвшөөрөөгүй бол Засгийн газар нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа буцалтгүй тусламж (тус бүрт нь **“Буцалтгүй тусламж”** гэх)-ийг олгох, зарцуулах, удирдан зохион байгуулах ажиллагааг МСК-ын шаардлагад нийцүүлэн, нээлттэй, шударга, өрсөлдөөний зарчмыг ил тод баримталсан байдлаар гүйцэтгэхийг үүгээр зөвшөөрөв. Энэхүү шаардлагын биелэлтийг хангах үүднээс, аливаа Буцалтгүй тусламжийг олгохын өмнө Засгийн газар болон МСК нь Буцалтгүй тусламжийг хүлээн авах боломжтой этгээдийг тогтоох журмыг бичгээр урьдчилан тохирох бөгөөд тэрхүү журамд уг этгээдэд тавигдах шаардлага, сонголт хийх шалгуур үзүүлэлт, шалгаруулалтын ажиллагаа болон бусад үйл явцын талаар тусгасан байна. Ийнхүү тохиролцсон журмыг Монголын МСК-гийн цахим хуудаст нийтэлнэ.

3.7. Хэсэг. Бүртгэл, нягтлан бодох бүртгэл, аудитад хамрагдах нийлүүлэгчид, нэвтрэх эрх.

(a) Засгийн газрын тайлан, бүртгэл. Засгийн газар өөрөө болон аудитад хамрагдах үүрэг бүхий бүх нийлүүлэгчид МСК-ын санхүүжилтийг МСК-аас тавьсан нөхцөл, шаардлагын дагуу зарцуулж байгааг нотлох зорилгоор Хөтөлбөртэй холбоотой нягтлан бодох бүртгэл, тайлан, баримт бичиг болон холбогдох бусад баримт мэдээллийг (нийтэд нь **“Компакт гэрээний тайлан, бүртгэл”** гэх) бүрдүүлэн хөтлөх нөхцөлийг хангаж, хяналт тавихаар чармайн ажиллахыг Засгийн газар үүгээр зөвшөөрөв. Түүнчлэн МСК-аас хүссэн тохиолдолд Засгийн газар нь Компакт гэрээний хүрээнд хөтөлсөн тайлан, бүртгэл, баримт бичгийг эх хувиар эсхүл хуулбарлан хүргүүлэх буюу ийнхүү хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг үүгээр зөвшөөрөв.

(b) Нягтлан бодох бүртгэл. Засгийн газар өөрөө болон аудитад хамрагдах үүрэг бүхий бүх нийлүүлэгчид АНУ-д нийтлэг мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлах, эсхүл Засгийн газраас сонгож, МСК-аас урьдчилан бичгээр зөвшөөрсний дагуу (i) Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс зөвлөмж болгодог, эсхүл (ii) Монгол Улсад нийтлэг мөрддөг зэрэг нягтлан бодох бүртгэлийн зарчмыг сонгон баримтлах нөхцөлийг бүрдүүлж, хяналт тавин ажиллахаар Засгийн газар үүгээр зөвшөөрөв. Компакт гэрээний тайлан, бүртгэлийг

Компакт гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дууссанаас хойш 5 (тав)-аас доошгүй жил, эсхүл болзошгүй зарга, нэхэмжлэл, аудитын дүгнэлтэд ашиглах болон хууль, эрх зүйн аливаа холбогдох шаардлагыг хангахад шаардлагатай хугацаагаар хадгална.

(с) Нэвтрэх эрх. Засгийн газар нь МСК-аас хүсэлт болгосны дагуу, МСК-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, МСК-ын Ерөнхий хянан шалгагч (“Ерөнхий хянан шалгагч” гэх), АНУ-ын Засгийн газрын Хариуцлагатай байдлын алба, энд дурдагдсан асуудлаар болон Компакт гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлаарх аудитын дүгнэлт гаргах үүрэг бүхий аливаа аудитор, эсхүл Хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, нягтлан шалгах, дүгнэлт үнэлгээ хийлгэхээр МСК, эсхүл Засгийн газраас томилсон төлөөлөгчдөд МСК-аас бүхэлд нь болон хэсэгчлэн санхүүжүүлсэн аливаа байгууламж, хөрөнгө, үйл ажиллагаанд аль ч үед аудит хийх, хянан шалгах, үнэлгээ хийх зөвшөөрөл олгох буюу ийнхүү зөвшөөрөл олгох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8. Хэсэг. Аудит, хяналт шалгалт.

(а) Засгийн газрын аудит. Талууд бичгээр өөрөөр тохироогүй бол Засгийн газар нь МСК-ын санхүүжилтийн нийт зарцуулалтад дор хаяж хагас жил тутам, энэхүү Компакт гэрээнд гарын үсэг зурснаас хойш дараа жилийн 3 дугаар сарын 31 эсхүл 9 дүгээр сарын 30-ны аль түрүүлж тохиох өдөр хүртэл, улмаар Компакт гэрээний хугацаа дуусах хүртэл 3 дугаар сарын 31 эсхүл 9 дүгээр сарын 30-ны өдрөөр таслан 6 сар тутамд санхүүгийн аудит хийх буюу хийлгэх нөхцөлөөр хангана. Түүнчлэн, Засгийн газар нь МСК-аас хүсэлт болгосны дагуу ийм аудитыг МСК-аас зөвшөөрч, “МСК-ын Эрх бүхий этгээдээс гэрээлсэн санхүүгийн аудитад баримтлах зааварчилгаа” (“Аудитын зааварчилгаа” гэх)-ны дагуу шалгаруулсан хараат бус аудитороор гүйцэтгүүлэх буюу ийнхүү гүйцэтгүүлэх нөхцөлөөр хангана. Аудитыг Аудитын зааварчилгааны дагуу гүйцэтгэх бөгөөд Аудит тус бүрийг аудитад хамрагдвал зохих хугацаанаас хойш 90 хоногийн дотор, эсхүл Талуудын бичгээр харилцан тохирсон хугацааны дотор гүйцэтгэж, тайланг МСК-д хүргүүлнэ. Аудит хийх хуваарьт оруулсан аливаа өөрчлөлтийг Монголын МСС-гаас Аудитын зааварчилгаа болон Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээний дагуу боловсруулж, МСК-аар батлуулан хэрэгжүүлж буй аудитын төлөвлөгөө (“**Аудитын төлөвлөгөө**” гэх)-нд тусгасан байна.

(б) Бусад этгээдийн аудит. Засгийн газар, эсхүл аливаа Нийлүүлэгч болон (i) АНУ-ын ашгийн бус байгууллагын хооронд байгуулсан МСК-аас санхүүжүүлж буй гэрээнд АНУ-д төвтэй ашгийн бус байгууллага нь АНУ-ын Удирдлага, төсвийн албанаас гаргасан Холбооны улсын худалдан авах гэрээнд нийтлэг үйлчлэх захиргааны болон аудитын шаардлага, зардлын зарчимд захирагдана гэдгийг заасан байх; (ii) АНУ-д төвтэй, аудитад



хамрагдах, ашгийн төлөө Нийлүүлэгчийн хооронд байгуулсан МСК-аас санхүүжүүлж буй гэрээнд, Засгийн газар болон МСК бичгээр өөрөөр тохироогүй бол, АНУ-ын Засгийн газрын холбогдох агентлагаас хийх аудитад хамрагдана гэдгийг заасан байх; (iii) АНУ-аас бусад улсад төвтэй, аудитад хамрагдах Нийлүүлэгч (ашгийн төлөө болон ашгийн бус аль аль нь орно)-ийн хооронд байгуулсан МСК-аас санхүүжүүлж буй гэрээнд тэрхүү Нийлүүлэгч нь Аудитын зааварчилгааны дагуу хийх аудитад хамрагдана гэдгийг тусгах үүргийг Засгийн газар хүлээхээ үүгээр зөвшөөрөв.

(с) Залруулах ажиллагаа. Засгийн газар нь аудитад хамрагдах Нийлүүлэгч тус бүрийг (i) аудитын шалгалтын үр дүнгийн дагуу шаардлагатай залруулах ажиллагааг тухай бүрт шуурхай хэрэгжүүлэх, (ii) үйл ажиллагаандаа хийсэн аудитын дүгнэлтийн дагуу Засгийн газрын тайлан, бүртгэлд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг авч үзэх, (iii) шаардлагатай тохиолдолд бүртгэл, санхүүгийн тайлантайгаа танилцах эрхийг хараат бус аудитуруудад олгох нөхцөлөөр хангахаар чармайн ажиллахаа үүгээр зөвшөөрөв.

(d) МСК-ын аудит. МСК нь өөрийн олгосон санхүүжилтийг Засгийн газар хэрхэн зарцуулж байгаад аудитын шалгалт хийлгэх эрхтэй.

(e) Аудит, хяналт шалгалт, үнэлгээний зардал. Энэхүү Компакт гэрээгээр шаардах аливаа аудит, хяналт шалгалт, үнэлгээний ажлын зардлыг МСК-ын санхүүжилтээс гаргаж болно.

3.9. Хэсэг. Оюуны өмч.

Засгийн газар нь одоогийн байдлаар мэдэгдэж байгаа болон цаашид бий болох Оюуны аливаа өмчийг өөрийн хүссэн хэлбэр, зорилгын дагуу ашиглах эрх болон тусгай зөвшөөрлийг (үүнд, өмчийг бүтээх, олшруулах, нийтлэх, зориулалтыг өөрчлөх, ашиглах, хадгалах, өөрчлөх, эсхүл түгээх зэргийг оруулна) МСК-д байнгын, эргэлт буцалтгүй, үнэ төлбөргүй, цааш шилжүүлэх боломжтой бөгөөд дэлхийн аль ч оронд үйлчлэх байдлаар олгов.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ ХАРИЛЦАА ХОЛБОО

4.1. Хэсэг. Харилцаа холбоо.

Энэхүү Компакт гэрээний дагуу Талууд харилцаа холбоог зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд МСК-тай өөрөөр тохиролцоогүй бол зөвхөн англи хэлээр гүйцэтгэнэ. Бүх харилцаа холбоог Талууд тус бүрийн заасан дараах хаягаар, эсхүл бичгээр харилцан мэдэгдсэн өөр бусад хаягаар хүргүүлнэ.

МСК-д:

Мянганы сорилтын корпорац

Компакт гэрээний үйл ажиллагаа эрхэлсэн Дэд ерөнхийлөгчийн анхааралд:

(Хуулбарыг Дэд ерөнхийлөгч бөгөөд Хуулийн ерөнхий зөвлөхөд)

1099 Fourteenth Street NW, Suite 700

Washington, DC 20005

United States of America

Факс: +1 (202) 521-3700

Утас: +1 (202) 521-3600

Цахим шуудан:

VPOperations@mcc.gov (Компакт гэрээний үйл ажиллагаа эрхэлсэн Дэд ерөнхийлөгч)

VPGeneralCounsel@mcc.gov (Дэд ерөнхийлөгч бөгөөд Ерөнхий зөвлөх)

Засгийн газарт:

Гадаад харилцааны яам

Хэнд:

Гадаад харилцааны сайдад

(Хуулбарыг Монголын МСС-гийн Гүйцэтгэх захиралд)

Энх тайвны өргөн чөлөө – 7А

Улаанбаатар хот – 14210

Монгол Улс

Факс: +976 - 11 - 322127

Утас: +976 - 51 - 262627

Цахим шуудан:

minister@mfa.gov.mn

Монголын МСС-д:

Монголын МСС байгуулагдсаныхаа дараа Талуудад өөрийн холбогдох хаягийг хүргүүлнэ.

4.2.Хэсэг. Төлөөлөгч. Энэхүү Компакт гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх асуудлаар Засгийн газрыг Монгол Улсын Гадаад харилцааны сайд эсхүл уг албан тушаалын үүрэг гүйцэтгэгч төлөөлөх бөгөөд МСК-ийг Компакт гэрээний үйл ажиллагаа эрхэлсэн Дэд ерөнхийлөгч эсхүл уг албан тушаалын үүрэг гүйцэтгэгч (тус бүрийг “Үндсэн төлөөлөгч” гэх) төлөөлнө. Талууд харилцан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр Компакт гэрээний 6.2(а)-аас бусад хэсэгт заасан зорилгоор нэг буюу түүнээс дээш тооны төлөөлөгчийг (тус бүрийг “Нэмэлт төлөөлөгч” гэх) нэмж томилж болно. Засгийн газар Монголын МСС-гийн Гүйцэтгэх захирлыг Нэмэлт төлөөлөгчөөр томилж байна. МСК нь Европ, Ази, Номхон далай, Латин Америкийн бүс нутаг хариуцсан Дэд ерөнхийлөгч болон МСК-ын Монгол Улс дахь Суурин захирлыг Нэмэлт төлөөлөгчөөр томилж байна. Талууд тус тусын Үндсэн төлөөлөгчийг ижил болон илүү өндөр түвшний албан тушаал



бүхий шинэ төлөөлөгчөөр сольж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ.

4.3. Хэсэг. Гарын үсэг. Энэхүү Компакт гэрээ болон Компакт гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг нэг хуудаст гарын үсэг зурах, эсхүл захидал буюу дипломат ноот бичиг солилцохыг жинхэнэ эх бичвэрт гарын үсэг зурсан гэж үзнэ .

5 ДУГААР ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ҮЙЛЧЛЭЛИЙГ ТҮР ЗОГСООХ, ДУУСГАВАР БОЛОХ

5.1. Хэсэг. Хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох.

(a) Аль ч Тал нөгөө Талдаа 30 (гуч) хоногийн дотор бичгээр мэдэгдсэнээр энэхүү Компакт гэрээг аливаа шалтгаан заалгүйгээр бүхэлд нь хүчингүй болгож болно. МСК нь мөн Засгийн газарт 30 (гуч) хоногийн өмнө бичгээр урьдчилан мэдэгдсэний дагуу аливаа шалтгаан заалгүйгээр Компакт гэрээ эсхүл МСК-ын санхүүжилтийг хэсэгчлэн хүчингүй болгож болно.

(b) МСК нь Компакт гэрээг хүчингүй болгох, үйлчлэлийг нь түр зогсоох үндэслэл болохуйц дараах болон бусад нөхцөл байдал үүссэн гэж тогтоовол, Засгийн газарт бичгээр мэдэгдэж, Компакт гэрээний үйлчлэл, МСК-ын санхүүжилтийг нэн даруй бүхэлд нь болон хэсэгчлэн түр зогсоох, эсхүл хүчингүй болгож болно. Үүнд:

(i) Засгийн газар нь энэхүү Компакт гэрээний дагуу хүлээсэн, эсхүл Компакт гэрээ болон Хөтөлбөртэй холбогдуулан байгуулсан аливаа гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

(ii) Энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, аливаа Нэмэлт гэрээнд Засгийн газраас оруулсан аливаа мэдэгдэл, нотолгоо, баталгаа, эсхүл Компакт гэрээтэй холбогдуулан Засгийн газраас хүргүүлсэн гэрчилгээ, бусад баримт бичиг нь тэдгээрийг хүргүүлэх үед алдаатай, эсхүл төөрөгдүүлсэн утгатай байсан;

(iii) Нэг, эсхүл удаа дараагийн үйл явдлын улмаас Төслийн зорилтыг Компакт гэрээ хэрэгжих хугацаанд биелүүлэх боломжгүй болсон, эсхүл Засгийн газар Компакт гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон;

(iv) МСК-ын санхүүжилтийг зарцуулах, эсхүл энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь одоо хүчин

төгөлдөр үйлчилж буй болон цаашид хүчин төгөлдөр үйлчлэх АНУ-ын холбогдох хууль тогтоомж, тус улсын Засгийн газрын бодлоготой зөрчилдөх;

(v) Засгийн газар, эсхүл МСК-ын санхүүжилтийг хүлээн авч, Хөтөлбөрийн өмч хөрөнгийг ашиглаж байгаа аливаа хувь хүн, хуулийн этгээд нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын эрх ашигт харшилсан үйл ажиллагаа явуулсан;

(vi) Гадаадын зээл, тусламжийн тухай АНУ-ын 1961 оны хуулийн аливаа заалт, эсхүл бусад хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсыг Гадаадын зээл, тусламжийн тухай АНУ-ын 1961 оны хуулийн I бүлэг, түүний нэмэлт, өөрчлөлт (22 U.S.C 2151 дугаар бүхий)-д заасны дагуу АНУ-ын эдийн засгийн тусламж хүлээн авах эрхгүй болгох аливаа үйлдэл, эс үйлдэл, үйл явдал тохиолдох;

(vii) Засгийн газар нь АНУ-ын Мянганы сорилтын тухай хуулийн дагуу Монгол Улсыг тусламж авах эрх бүхий орноор тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдэд үл нийцэх үйл ажиллагааг удаа дараа үйлдсэн;

(viii) МСК-ын санхүүжилтийг хүлээн авч буй, эсхүл Хөтөлбөрийн өмч хөрөнгийг ашиглаж байгаа аливаа хувь хүн, хуулийн этгээд хар тамхи, мансууруулах бодисын гэмт хэрэгт холбогдон яллагдсан, эсхүл хар тамхи, мансууруулах бодисыг худалдан борлуулахад оролцсон нь тогтоогдсон зэрэг нөхцөл хамаарна.

5.2. Хэсэг. Компакт гэрээг хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох, дуусгавар болохоос үүдэх үр дагаврууд.

(a) Энэхүү Компакт гэрээний үйлчлэл, эсхүл МСК-ын санхүүжилтийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түр зогсоосон, хүчингүй болгосон, эсхүл Компакт гэрээ дуусгавар болсон тохиолдолд МСК-ын санхүүжилт болон холбогдох аливаа Зарцуулалт, Хөтөлбөрийн өмч хөрөнгөтэй холбоотой аливаа асуудлыг Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу зохицуулна. Энэхүү Компакт гэрээ, МСК-ын санхүүжилт, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон бусад Нэмэлт гэрээний үйлчлэлийг зогсоогоогүй болон хүчингүй болгоогүй хэсгүүд хүчин төгөлдөр үйлчилсэн хэвээр байна.

(b) Засгийн газар, эсхүл холбогдох хувь хүн, эсхүл хуулийн этгээд нь МСК-ын санхүүжилтийг түр зогсоосон, эсхүл хүчингүй болгосон нөхцөл шалтгааныг залруулах арга хэмжээ авсан гэж МСК үзсэн тохиолдолд санхүүжилтийн түр зогсоосон, эсхүл хүчингүй болгосон хэсгийг буцаан сэргээж болно.



5.3. Хэсэг. Буцаан төлөх; Зөрчил.

(a) МСК-ын санхүүжилт, түүнээс олсон аливаа орлого, хүү, эсхүл Хөтөлбөрийн өмч хөрөнгийг Компакт гэрээний нөхцөлтэй харшлах зорилгоор ашигласан тохиолдолд МСК тэрхүү хөрөнгө болон түүнээс олсон аливаа орлого, хүү, өмч хөрөнгө болон Компакт гэрээний 5.4. дэх хэсэгт заасан хүүг буцаан төлөх шаардлагыг Засгийн газарт хүргүүлж, Засгийн газар тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 (гуч) хоногийн дотор ам.доллараар буцаан олгохыг шаардаж болно. Засгийн газар МСК-ын санхүүжилт, түүнээс олсон орлого, эсхүл Хөтөлбөрийн өмч хөрөнгийг тухайн төлбөрийг барагдуулахад ашиглахгүй гэдгээ үүгээр зөвшөөрөв.

(b) Энэхүү Компакт гэрээний бусад заалт, эсхүл эсрэг агуулгатай өөр бусад гэрээ хэлэлцээрээс үл хамааран 5.3(a) дахь хэсэгт заасны дагуу МСК-ын буцаан төлүүлэх эрх нь Компакт гэрээний хугацаанд болон (i) түүнээс хойш таван жилийн хугацаанд, эсхүл (ii) Компакт гэрээний нөхцөлийг зөрчсөн тухай бодит мэдээллийг МСК хүлээн авснаас хойш нэг жилийн хугацаанд буюу эдгээрээс аль хожуу тохиосон хугацааны туршид хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.4. Хэсэг. Хожуу төлөлтийн хүү.

Засгийн газар энэхүү Компакт гэрээ, эсхүл Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заасан (2.8(c) болон 5.3(a) дахь хэсэгт заасан үнийн дүнг оролцуулан) дүнг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд уг дүнд хүү тооцно. Хугацаа хэтэрсэн дүнд тооцох хүүг АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасны тухайн үеийн хүүгийн ханшаар бодох бөгөөд нэг жилийг 360 хоногоор тооцож, бүтэн барагдуулах хүртэл уг ханш үйлчилнэ. Засгийн газрын төлөх мөнгөн дүн нь хүүгийн төлбөрийг барагдуулахад эхэлж зарцуулагдах бөгөөд хүүгийн төлбөрийг барагдуулж дууссаны дараа төлөгдөөгүй үлдсэн үндсэн дүнгээс хасагдана.

5.5. Хэсэг. Үйлчлэл хэвээр хадгалагдах.

Энэхүү Компакт гэрээний 2.8 дахь хэсгийн заалт Компакт гэрээ дуусгавар болсон өдрөөс хойш зөвхөн 120 хоногийн дотор хүчинтэй хэвээр үйлчлэх тохиолдолд, Компакт гэрээний энэ хэсэг болон 2.7 (МСК-ын санхүүжилтийг ашиглахад тавигдах хязгаарлалт), 2.8 (Татвар), 3.7 (Архив хөтлөлт, нягтлан бодох бүртгэл, аудитад хамрагдах үүрэг бүхий нийлүүлэгчид, нэвтрэх эрх), 3.8 (Аудит, хяналт шалгалт), 3.9 (Оюуны өмч), 5.2 (Гэрээг хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох, дуусгавар болохоос үүдэн гарах үр дагаврууд), 5.3 (Буцаан төлөх, Зөрчил), 5.4 (Хожуу төлөлтийн хүү), 6.4 (Хэрэглэх хууль, статус) дэх хэсэгт заасан Засгийн газрын хүлээх үүрэг нь Компакт гэрээний хугацаа дуусч, үйлчлэлийг түр зогсоож, хүчингүй болсны дараа хүчинтэй хэвээр хадгалагдана.

6 ДУГААР ЗҮЙЛ
КОМПАКТ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ, НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ, ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ

6.1. Хэсэг. Хавсралт.

Энэхүү Компакт гэрээний Хавсралт бүр нь Компакт гэрээний салшгүй хэсэг бөгөөд өөрөөр тусгайлан заагаагүй тохиолдолд “Хавсралт” гэдгийг Компакт гэрээний хавсралт гэж үзнэ.

6.2. Хэсэг. Нэмэлт, өөрчлөлт.

(а) Талууд зөвхөн бичгээр харилцан тохиролцсоны дагуу Компакт гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Бичгээр ийнхүү тохиролцоходоо тухайн нэмэлт, өөрчлөлт хэрхэн хүчин төгөлдөр болох талаар мөн заана.

(б) Энэхүү Компакт гэрээний 6.2(а) дахь хэсгийн заалтыг үл харгалзан Талууд аливаа Хавсралтад (i) Төсөл, эсхүл аливаа Үйл ажиллагааг түр зогсоох, хүчингүй болгох, өөрчлөх, (ii) II Хавсралтад заасан санхүүжилтийн хуваарилалтыг өөрчлөх, (iii) I Хавсралтад заасан хэрэгжилтийн бүтцийг өөрчлөх, (iv) МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод нийцүүлэн III Хавсралтад заасан аливаа үзүүлэлт, суурь үзүүлэлт, зорилтот түвшин болон бусад мэдээллийг өөрчлөх, хасах, эсхүл шинээр нэмэх, эсхүл (v) IV Хавсралт эсхүл, V Хавсралтад заасан Урьдчилсан болзолт нөхцөлийг өөрчлөх, хасах, эсхүл шинээр нэмэх гэсэн нэмэлт, өөрчлөлтийг бичгээр хэлэлцээр байгуулж, нэмэлт гарын үсэг зурсны үндсэн дээр хүчин төгөлдөр болох байдлаар оруулж болох бөгөөд ингэхдээ уг өөрчлөлт нь (А) Төслийн зорилттой бүх талаар нийцэж байх, (В) Хөтөлбөрийн санхүүжилтийг 2.1 хэсэгт заасан Хөтөлбөрийн санхүүжилтийн нийт дүн (энэ дүнд 2.2(с) хэсгийн дагуу өөрчлөлт орж болно)-ээс хэтрүүлэхгүй байх, (С) Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийг 2.2(а) хэсэгт заасан нийт дүнгээс хэтрүүлэхгүй байх, (D) Компакт гэрээний 2.6(а)(ii) дахь хэсгийн дагуу МСК-ын хүлээн зөвшөөрснөөс бусад байдлаар 2.6(а) дахь хэсэгт заасан Засгийн газрын үүрэг хариуцлага, оруулах хувь хэмжээг бууруулахгүй байх, (Е) Компакт гэрээний хэрэгжилтийн хугацааг сунгахгүй байх шаардлагыг хангана.

6.3. Хэсэг Үл нийцэл. Дараах зүйлсийн хооронд аливаа зөрчил, үл нийцэл гарсан тохиолдолд:

(а) Компакт гэрээний хавсралт болон 1-ээс 8 дугаар зүйлийн аль нэгний хувьд 1-ээс 8 дугаар зүйлд заасныг баримтална;

(б) Компакт гэрээ болон Хөтөлбөрийн талаар Талуудын байгуулсан аливаа бусад хэлэлцээрийн хувьд энэхүү Компакт гэрээг баримтална.



6.4. Хэсэг. Хэрэглэх хууль. Энэхүү Компакт гэрээ нь олон улсын гэрээ мөн бөгөөд олон улсын эрх зүйгээр зохицуулагдана.

6.5. Хэсэг Нэмэлт эх сурвалж. Энэхүү Компакт гэрээнд заасан, эсхүл Компакт гэрээг хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаа, эрх үүргийн талаарх эшлэл, эсхүл ижил төстэй хэллэг нь энэхүү Компакт гэрээ болон Хөтөлбөртэй холбоотой хэлэлцээр, баримт бичиг, эх сурвалжийн дагуу түүнийг хэрэгжүүлэх зорилгоор явуулж буй аливаа үйл ажиллагаа, хүлээх үүрэг, эдлэх эрхэд хамаарна.

6.6. Хэсэг. МСК-ын цахим хуудас мэдээллийн эх сурвалж болох тухай. Өөрөөр тусгайлан заагаагүй бол, энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон энэхүү Компакт гэрээтэй холбоотой байгуулсан аливаа хэлэлцээрт дурдах баримт бичиг, мэдээллийн эх сурвалж гэж МСК-ын цахим хуудаст байршуулсан болон тухай бүр шинэчлэн байршуулах баримт бичиг, мэдээллийг хэлнэ.

6.7. Хэсэг. Хууль, журам, бодлого, зааварчилгаа нь мэдээллийн эх сурвалж болох тухай болон Компакт гэрээ дуусгавар болох, хүчингүй болоход баримтлах эх сурвалжийн тухай.

(a) Өөрөөр тусгайлан заагаагүй бол, энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, эсхүл энэхүү Компакт гэрээтэй холбоотой байгуулсан бусад хэлэлцээрт дурдсан аливаа хууль, журам, бодлого, зааварчилгаа, эсхүл адил төстэй баримт бичиг гэдэгт тухайн хууль, журам, бодлого, зааварчилгаа, эсхүл адил төстэй баримт бичиг болон тэдгээрт тухай бүр оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга, оронд нь шинээр хүчин төгөлдөр болсон хувилбар болон тэдгээртэй холбогдуулан баталсан бусад хууль, журам, бодлого, зааварчилгаа эсхүл адил төстэй баримт бичгийг хамааруулан ойлгоно.

(b) Энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, эсхүл энэхүү Компакт гэрээтэй холбогдон байгуулсан бусад хэлэлцээрт дурдсан Компакт гэрээ “дуусгавар болох хугацаа” гэж Компакт гэрээг өмнө нь хүчингүй болгоогүй нөхцөлд баримтлах, 7.4. хэсэгт заасан Компакт гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дараа Компакт гэрээний хугацаа дуусах огноог хэлнэ. Эдгээр баримт бичигт Компакт гэрээг “хүчингүй болгох” хэмээн заасан нь энэхүү Компакт гэрээ 5.1. хэсэгт заасан дуусгавар болох хугацаанаас өмнө хүчингүй болох агуулгыг илэрхийлнэ.

6.8. Хэсэг. МСК-ын статус. МСК нь энэхүү Компакт гэрээг хэрэгжүүлэхээр АНУ-ын Засгийн газрын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй АНУ-ын Засгийн газрын байгууллага бөгөөд МСК болон АНУ-ын Засгийн газар энэхүү Компакт гэрээний дагуу хэрэгжүүлсэн үйл

ажиллагаа, эсхүл алдаанаас шалтгаалан гаргасан аливаа нэхэмжлэл, алдагдалтай холбогдуулан хариуцлага хүлээхгүй болно. Засгийн газар нь энэхүү Компакт гэрээний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, эсхүл алдаанаас шалтгаалан гарах алдагдал, хохирол, гэмтэл, эсхүл амь насаа алдсан тохилдолтой холбогдуулан МСК болон АНУ-ын Засгийн газар, эсхүл МСК болон АНУ-ын Засгийн газарт одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан аливаа ажилтан, албан тушаалтны эсрэг аливаа нэхэмжлэл гаргахгүй бөгөөд эдгээр хувь хүн, хуулийн этгээдийн эсрэг аливаа алдагдал, хохирол, гэмтэл, эсхүл амь насаа алдсан тохиолдолтой холбоотой хуулийн аливаа арга хэмжээ авахгүй. Засгийн газар нь МСК болон АНУ-ын Засгийн газар, эсхүл МСК болон АНУ-ын Засгийн газарт одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан аливаа ажилтан, албан тушаалтан нь энэхүү Компакт гэрээний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, эсхүл алдаанаас шалтгаалан гаргасан аливаа нэхэмжлэл, алдагдалтай холбогдуулан Монгол Улсын бүх шатны шүүх байгууллагын өмнө халдашгүй эрхтэй болохыг үүгээр зөвшөөрөв.

6.9 Хэсэг. Зөвлөлдөх ажиллагаа. Энэхүү Компакт гэрээг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбогдуулан аль ч Тал нь нөгөө Талтайгаа зөвлөлдөх хүсэлт хэдийд ч гаргаж болно. Ийм зөвлөлдөх ажиллагааг хамгийн ойрын боломжит хугацаанд эхлүүлнэ.

7 ДУГААР ЗҮЙЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

7.1. Хэсэг. Дотоодын үйл явц. Засгийн газар нь энэхүү Компакт гэрээг хүчин төгөлдөр болоход шаардлагатай дотоодын бүх үйл ажиллагааг цаг тухайд нь хангахаа үүгээр зөвшөөрөв. Энэхүү Компакт гэрээ хүчин төгөлдөр болж Монгол Улсын хууль болохын хувьд Монгол Улсын хууль тогтоомжоос давуу хүчинтэй үйлчилнэ. Засгийн газар 7.3. дахь хэсэгт заасан захидлыг хүргүүлэхийн өмнө Монгол Улсын холбогдох хуулийн дагуу энэхүү Компакт гэрээг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, соёрхон батлуулна гэдгийг Талууд үүгээр тохиролцов.

7.2. Хэсэг. Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах урьдчилсан болзолт нөхцөлүүд. МСК нь дараах нөхцөл тус бүрийг хангалттай биелсэн гэж үзсэний дараа энэхүү Компакт гэрээ хүчин төгөлдөр болно. Үүнд:

- (a) Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд Талууд гарын үсэг зурсан байх;
- (b) Засгийн газар МСК-д дараах зүйлийг хүргүүлсэн байх:

(i) Засгийн газар энэхүү Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардлагатай дотоодын бүх үйл ажиллагааг дуусгасан байх



бөгөөд энэхүү Компакт гэрээний 7.2 дахь хэсэгт заасан урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хангасан болохыг гэрчилсэн Засгийн газрын Үндсэн төлөөлөгч, эсхүл Засгийн газраас зохих ёсоор эрх олгож, МСК-аас хүлээн зөвшөөрсөн төлөөлөгчийн гарын үсэг, огноо бүхий захидал;

(ii) Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд (эсхүл Засгийн газраас томилж, МСК-аас хүлээн зөвшөөрсөн хуулийн төлөөлөгч)-аас ирүүлсэн, МСК-аас тавьсан шаардлагыг хангасан хэлбэр, агуулга бүхий хууль зүйн дүгнэлт;

(iii) МСК өөрийн цахим хуудаснаа байрлуулах буюу өөр бусад байдлаар нийтийн хүртээл болгож болох, Компакт гэрээ болон Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ хүчин төгөлдөр болоход баримтлах Монгол Улсын дотоодын үйл ажиллагаатай холбоотой бүх хууль, зарлиг, тушаал, журам буюу Засгийн газрын бусад баримт бичгийн бүрэн, баталгаажсан хуулбар.

(c) Компакт гэрээнд гарын үсэг зурсны дараа Засгийн газар нь Монгол Улсыг тусламж авах эрх бүхий орноор тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд үл нийцэх үйл ажиллагаа явуулаагүй болохыг МСК-аас магадлан тогтоосон байх.

(d) V Хавсралтад заасан нөхцөлүүд биелсэн байх.

7.3. Хэсэг. Хүчин төгөлдөр болох огноо. Энэхүү Компакт гэрээ нь Талууд Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардлагатай тус тусын дотоодын үйл ажиллагааг хэрэгжүүлж дууссан бөгөөд Засгийн газар Компакт гэрээний 7.2 дахь хэсэгт заасан урьдчилсан болзолт нөхцөлүүдийг МСК-ын шаардлагад нийцүүлэн хангасан тухай МСК-аас Засгийн газарт ирүүлсэн захидлын огноогоор хүчин төгөлдөр болно.

7.4. Хэсэг. Компакт гэрээний хугацаа. Энэхүү Компакт гэрээ нь 5.1 дэх хэсгийн дагуу хугацаанаасаа өмнө цуцлагдсанаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ (“Компакт гэрээ хэрэгжих хугацаа” гэх).

7.5 Хэсэг. Компакт гэрээ нөхцөлтэйгээр үйлчлэх нь. Энэхүү Компакт гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 7.3 дахь хэсгийн дагуу хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд Талууд Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтээс бусад МСК-ын санхүүжилтийг зарцуулах нөхцөлийг олгохгүй, эсхүл зарцуулахгүй гэсэн нөхцөлтэйгээр Компакт гэрээг хэрэгжүүлнэ.

8 ДУГААР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЛЭЭХ НЭМЭЛТ ҮҮРЭГ

8.1. Хэсэг. Усны салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой үүрэг. Засгийн газар нь энэхүү Компакт гэрээ хэрэгжих хугацаанд ус хангамж, хаягдал ус татан зайлуулах, цэвэршүүлэх үйлчилгээтэй холбоотой улсын төсвийн хөрөнгө оруулалтын түвшинг хэвээр хадгалах, эсхүл нэмэгдүүлэхийг үүгээр зөвшөөрөв.

8.2. Хэсэг. “Бохирдуулагч нь төлөх” зарчмын хэрэгжилттэй холбоотой үүрэг. Засгийн газар нь бохирдуулагч хувь хүн, хуулийн этгээд тэрхүү бохирдлоос үүдэлтэй нийгэм, байгаль орчин, эдийн засгийн өртгийг бүхэлд нь хариуцан төлөх зарчим (“Бохирдуулагч нь төлөх зарчим” гэх)-ыг тусгасан холбогдох бүх хууль тогтоомж, түүний дотор Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг эрчимтэй хангах ажиллахаа үүгээр зөвшөөрөв.

8.3. Хэсэг. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй холбоотой үүрэг. Засгийн газар нь зардлыг бүрэн нөхөх хууль, эрх зүйн шаардлагад тулгуурлан Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар (“УСУГ” гэх)-аас боловсруулж ирүүлсэн үнэ, тарифын саналтай холбоотой эцсийн шийдвэрийг хөндлөнгийн аливаа оролцоо, саадгүйгээр гаргах нөхцөлөөр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” гэх)-ийг хангахаа үүгээр зөвшөөрөв.

8.4. Хэсэг. Мэдээлэл солилцохтой холбоотой үүрэг. Засгийн газар нь Хөтөлбөр, түүний дотор Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг хугацаанд нь хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тоо баримтыг гаргаж өгөх бөгөөд ингэхдээ Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол давтамжтайгаар хүргэнэ.

ГАРЫН ҮСЭГ ДАРААГИЙН ХУУДАСТ ЗУРАГДАНА



ҮҮНИЙГ ГЭРЧИЛЖ, Талууд зохих ёсоор бүрэн эрх олгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан энэхүү Компакт гэрээг англи хэл дээр 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр АНУ-ын Вашингтон хотноо байгуулав.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМААР
ТӨЛӨӨЛҮҮЛЭН МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МЯНГАНЫ СОРИЛТЫН
КОРПОРАЦААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН
АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

Нэр:
ДАМДИНЫ ЦОГТБААТАР

Нэр:
РОБЕРТ И. БЛАУ

Албан тушаал:
Гадаад харилцааны сайд

Албан тушаал:
Компакт гэрээний үйл ажиллагаа
эрхэлсэн Дэд ерөнхийлөгч

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН МЯНГАНЫ
СОРИЛТЫН КОРПОРАЦААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН АМЕРИКИЙН
НЭГДСЭН УЛС ХООРОНДЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН
КОМПАКТ ГЭРЭЭНИЙ ГАРЫН ҮСГИЙН ХУУДАС**

I ХАВСРАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Энэхүү I Хавсралтад Компакт гэрээний хугацаанд Монгол Улсад МСК-ын санхүүжилт болон Засгийн газраас оруулах хувь хэмжээгээр санхүүжүүлэн хэрэгжүүлэх Хөтөлбөрийн талаар тусгав.

A. ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ

1. Ерөнхий мэдээлэл, зөвлөлдөх үйл явц

(a) Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Мянганы сорилтын анхны Компакт гэрээ 2013 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр дуусгавар болсон. Талууд уг Компакт гэрээнд 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурж, Компакт гэрээ 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд хөрөнгийн эрх, эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, эрчим хүч, байгаль орчин, зам тээврийн салбарт хэрэгжсэн.

МСК нь 2015 оны санхүүгийн жилийн Үнэлгээний карт дахь Монгол Улсын үзүүлэлтүүдийг харгалзан, 2014 оны 12 дугаар сард Монгол Улсыг хоёр дахь удаагаа Компакт гэрээ боловсруулах боломжтой орноор шалгаруулсан. Улмаар Засгийн газраас Үндэсний зохицуулагч томилж, МСК-тай байгуулах хоёр дахь Компакт гэрээг боловсруулах үүрэг бүхий Үндэсний ажлын алба ("**Үндэсний ажлын алба**" гэх)-ыг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулсан болно.

Үндэсний ажлын алба нь МСК-тай хамтран Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн судалгааг гүйцэтгэсэн бөгөөд "ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өртөг өндөр" байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хамгийн ихээр хязгаарлаж буй хүчин зүйлсийн нэг хэмээн тогтоосон. Монгол Улсын нийт хүн амын тал хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг бөгөөд улсын хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуй нэгжийн дөрөвний гурав нь нийслэлд үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын эдийн засгийн гуравны хоёрыг дангаараа бүрдүүлдэг. Улаанбаатар хот сүүлийн хорь гаруй жилийн турш хурдтай тэлсний улмаас ойрын ирээдүйд буюу 2021 он гэхэд ундны ахуйн усны хомсдолд орохоор байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг сааруулж, оршин суугчдын амьдралын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. МСК болон Үндэсний ажлын алба хамтран 2016-2018 онуудад нарийвчилсан судалгаа хийсний дүнд газрын доорх усны шинэ эх үүсвэр байгуулах, хаягдал усыг дахин боловсруулж, ашиглах, усны салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах гэсэн чиглэлээр хөрөнгө оруулахаар тогтсон. Хөрөнгө оруулалтын эдгээр чиглэл нь усны салбарын засаглалыг илүү төвлөрсөн, үр ашигтай хэлбэрт оруулах Засгийн газрын байр суурьтай нийцэж байгаа болно.



(b) Зөвлөлдөх үйл явц

Компакт гэрээ боловсруулах явцад Засгийн газар Хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэл, агуулгыг тодорхойлох зорилгоор холбогдох талуудын оролцоог хангасан, стратегийн зөвлөлдөх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Урьдчилсан судалгаа гүйцэтгэх шатанд Засгийн газар болон орон нутгийн удирдлага, иргэний нийгэм, олон улсын хөгжлийн түнш байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл хамтран эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлоход оролцож, тэдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжид хэрхэн нөлөөлж байгааг авч үзсэн. Улмаар Засгийн газрын зүгээс төслийн бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох зорилгоор иргэний нийгэм, мэргэжлийн холбоод, хөгжлийн түнш байгууллагууд, улс төрийн намууд болон холбогдох бусад этгээдтэй хамтран ажиллаж, тэдгээрээс чиглэл, санал зөвлөмжийг авч ажилласан болно. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд Засгийн газар энэхүү зөвлөлдөх үйл явцыг үргэлжлүүлэн хангана.

2. Хөтөлбөр болон Хөтөлбөрийн үр өгөөжид хамрагдах зорилтот бүлэг

(a) Хөтөлбөрийн тухай

Энэхүү Хөтөлбөр нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлсийн нэг болох “ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өндөр өртөг” гэх асуудалд төвлөрөх бөгөөд нийслэл Улаанбаатар хотын ус хангамжийг хязгаарлагдмал нөөцөөс урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэхэд чиглэнэ. Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд харилцан уялдаа бүхий дараах гурван үйл ажиллагаанд хөрөнгө оруулна. Үүнд: Газрын доорх усны баруун эх үүсвэр буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг (Биокомбинат, Шувуун фабрик орчим)-т орших эх үүсвэрийг шинээр байгуулах, Хаягдал усыг дахин боловсруулах, Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа багтана.

(b) Хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэх зорилтот бүлэг

Компакт гэрээний хугацаа дуусахад энэхүү Хөтөлбөрөөс 656,124 гаруй өрх (ойролцоогоор 2,427,657 хүн) ашиг тус хүртэнэ гэж тооцсон. Улаанбаатар хотын нийт хүн ам бүхэлдээ энэхүү Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн үр өгөөжийг хүртэх юм.

В.ТӨСЛИЙН ТУХАЙ

Засгийн газар нь Төслийн зорилтыг биелүүлэхдээ МСК-ын санхүүжилт болон өөрийн оруулах хувь хэмжээгээр дараах Төсөл, тухайлсан үйл ажиллагаа (“Үйл ажиллагаа” гэх)-г санхүүжүүлэн хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэх нөхцөлийг хангана. Үүнд:

1. Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл.

(a) Төслийн тойм болон Үйл ажиллагаа

Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Төслийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий дараах Үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд: (i) Газрын доорх усны баруун эх үүсвэр буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг (Биокомбинат, Шувуун фабрик орчим)-т орших эх үүсвэрийг шинээр байгуулах; (ii) Хаягдал усыг дахин боловсруулах; (iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах гэсэн үйл ажиллагаа багтана.

(i) Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа

Улаанбаатар хотын баруун доод хэсэгт орших Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн шинэ эх үүсвэр байгуулна. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) хоёр шинэ эх үүсвэрт нийт 52 гүний худаг байгуулах, (ii) шахуурга, эх үүсвэр дотор ус цуглуулах шугам хоолой, тохируулгын усан сан болон усыг эх үүсвэрийн талбайгаас ус дамжуулах шугам хоолойг суурилуулах, (iii) усны бохирдлыг (газрын доорх усанд агуулагдаж болзошгүй патоген эмгэг үүсгэгч, дэгдэмхий органик нэгдэл, хүнд метал, бусад бохирдуулагч бодисыг олон шатлалаар цэвэршүүлэх) гүн цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий байгууламжийг Улаанбаатар хотын баруун доод хэсэгт байгуулах, (iv) нөөцийн сан, шахуургын станц, усыг гүн цэвэршүүлэх байгууламжаас Улаанбаатар хотын одоогийн ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд дамжуулахад шаардлагатай шугам хоолойг татах зэрэг багтана.

(ii) Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа

“Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа”-ны хүрээнд Төв цэвэрлэх байгууламж (ТЦБ)-аас гарах их хэмжээний цэвэрлэсэн хаягдал усыг дахин боловсруулж, ашиглана. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан МСК-ын санхүүжилтийг дараах ажлыг гүйцэтгэхэд зарцуулна. Үүнд: (i) ТЦБ-аас гарах цэвэршүүлсэн бохир усны тодорхой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрийг ТЦБ-ийн хажууд байрлах нийтийн эзэмшлийн талбайд байгуулах, (ii) дахин боловсруулсан усыг гурав болон дөрөвдүгээр Дулааны цахилгаан станц (ДЦС) (тус тус “ДЦС-3,” “ДЦС-4” гэх)-ын дэргэдэх усны нөөцийн сав руу дамжуулах шугам хоолой, шахуургын станц байгуулах, (iii) ДЦС-3 болон ДЦС-4-ийн зарим үйл ажиллагаанд дахин боловсруулсан усыг ашиглахад шаардлагатай хяналтын систем, дотоод шугам хоолой, нөөцийн савыг байгуулах барилга угсралтын ажил багтана.



(iii) Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа

“Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа” нь бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчин, институцийн асуудлыг хамарсан таван арга хэмжээнээс бүрдэх бөгөөд Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулахад чиглэгдэнэ.

(a) Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа

“Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа”-ны хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд ингэхдээ ус хангамжийн сайжруулсан үйлчилгээнд УСУГ-ын хэрэглэгчдийн төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийг нарийвчлан үнэлж, уг үнэлгээнд тулгуурлан цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судална. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, элэгдэл хорогдлын зардлыг бүрэн нөхөх чадварыг бий болгох тарифын хувилбаруудыг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад УСУГ-т туслалцаа үзүүлнэ.

(b) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа

“Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа”-ны хүрээнд Улаанбаатар хотын гэр хороололд ус түгээх байраар дамжуулан ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд УСУГ-аас зарцуулж буй өндөр зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ дэд үйл ажиллагааны хүрээнд ус хангамжийн үйлчилгээг хүргэх, борлуулахтай холбоотой гардаг шууд зардлыг бууруулах зорилго бүхий, цар хүрээний хувьд харьцангуй бага ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд: Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг «ухаалаг» буюу автомат ажиллагаанд шилжүүлэх, зөөврийн ус хангамж бүхий ус түгээх байруудыг байнгын/төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох зорилгоор ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, УСУГ-ын зөөврийн ус хангамжийн машины ус түгээхэд зарцуулдаг хугацаа, туулдаг зайг багасгах зорилгоор ачилтын худаг нэмж барих зэрэг ажлууд багтана. Түүнчлэн, нийслэлийн хэмжээнд ус хангамжийн дэд бүтцийг өргөжүүлж, хөгжүүлэх асуудлаар УСУГ болон нийслэл, дүүргийн харьяа байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, төлөвлөлт, уялдаа холбоо сайжруулахад туслалцаа үзүүлнэ.

(c) Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа

“Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа” нь ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ,

харьцуулалт хийхэд зориулж Олон улсын усны нийгэмлэгээс боловсруулсан олон улсын «AquaRating» үнэлгээний аргачлалыг ашиглан УСУГ-ын үйл ажиллагааны чадавхыг тодорхой чиглэлүүдээр сайжруулах зорилготой. Энэ хүрээнд, УСУГ-ыг үйл ажиллагааны хувьд ижил төстэй, нийтлэг бэрхшээл бүхий, хөгжингүй орны, өндөр туршлагатай ус ашиглалтын байгууллагатай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтооход шаардлагатай санхүүгийн туслалцааг үзүүлнэ. Түүнчлэн, УСУГ-ын хөрөнгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ (тухайлбал, төлөвлөх, захиран зарцуулах, ашиглалттай холбоотой засвар үйлчилгээг гүйцэтгэх зэрэг) хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, үр дүнг оновчтойгоор ашиглах чадварыг сайжруулахад чиглэсэн тодорхой тусламжийг үзүүлнэ.

(d) Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа

“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа” нь шинэ төв цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад орохоос урьтаж нийслэлийн хаягдал ус татан зайлуулах систем дэх үйлдвэрийн бохирдлын түвшинг бууруулах хүчин чармайлтыг дэмжих зорилготой. Үүнд, үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, түүнд шаардлагатай загварчлалыг боловсруулах, хаягдал усны стандартыг сайжруулах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, бохирдлыг хянах дүрэм журмыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ багтана. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж, лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангана.

(e) Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагаа

“Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагаа”-ны хүрээнд Улаанбаатар хотод нүүрлэж буй усны нөөцийн хомсдолын талаар болон байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх ашигт нийцсэн байдлаар ус олборлох, ашиглахтай холбоотой бодит өртгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор холбогдох талууд, олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

(b) Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл

Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, нийгмийн байдалд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул МСК-ын Байгаль орчны



зааварчилгааны дагуу уг үйл ажиллагааг “А ангилал”-д хамааруулж үзнэ. Энэхүү сөрөг нөлөөлөл нь гүйцэтгэж буй үйл ажиллагаанаас шалтгаалан зөвхөн төсөл хэрэгжиж буй талбар, барилга байгууламжийн талбайгаар хязгаарлагдахгүй, илүү өргөн талбайг хамарч байгаль орчин, нийгмийн байдалд эмзэг, олон янзын байдлаар илэрч болно. Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагааны хувьд байгаль орчин, нийгмийн байдалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн дийлэнх нь төслийн талбараар хязгаарлагдах бөгөөд зайлшгүй илэрч болох зарим цөөн сөрөг нөлөөг саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой тул “В ангилал”-ын үйл ажиллагаанд хамааруулна. Харин Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх мэдэгдэхүйц сөрөг нөлөө бага тул “С ангилал”-ын үйл ажиллагаа хэмээн тооцно.

(с) Төслийн хүрээнд нийгэм, жендэрийн асуудлыг авч үзэх нь

Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь МСК-ын Жендэрийн бодлого болон Жендэрийн асуудлыг төсөл, хөтөлбөрт тусгах зааварчилгаанд тус тус нийцэж байна. Засгийн газар нь Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай жендэрийн үнэлгээг гүйцэтгэсэн, цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх бөгөөд Төслийн загварыг боловсруулахдаа хүйсээр ангилсан тоо баримт ашиглан, нийгмийн тэгш байдлыг хангах асуудлыг тусгасан. Түүнчлэн, Засгийн газар нь Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчин, нийгмийн суурь судалгаа болон нүүлгэн суурьшуулалтын бодлогын баримт бичгийг боловсруулсан бөгөөд Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааны хувьд техникийн болон байгаль орчин, нийгэм, нүүлгэн суурьшуулалтын зэрэг тулгамдсан асуудлуудыг хамарсан үнэлгээг техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны түвшинд гүйцэтгэсэн.

Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь ойрын ирээдүйд Улаанбаатар хотод нүүрлэх усны хомсдолыг бууруулах замаар нийт ус хэрэглэгчдэд үр өгөөжөө өгөх хэдий ч уг төслийн хүрээнд усны хүртээмж, хэрэглээтэй холбоотой тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа тухайлан авч хэрэгжүүлэхгүй. УСУГ-ын Зардал нөхөх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шинээр бий болох ус хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хийх тарифын бүтэц, тоо хэмжээний аливаа өөрчлөлт нь Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд хүлээн зөвшөөрөхүйц бөгөөд худалдан авах чадварт нь нийцсэн байх ёстой. Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд нийгмийн тогтвортой байдалд учирч болох эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээг авч үзсэн бөгөөд тэдгээрийг (f) хэсэгт тодорхойлсон болно.

(d) Хандивлагчдын үялдаа холбоог хангах

Олон улсын хөгжлийн түншүүд нь боловсрол, эрүүл мэнд, зам тээвэр болон дэд бүтэц зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжлийн өргөн цар хүрээтэй асуудлаар Засгийн газарт идэвхтэй туслалцаа үзүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд эдгээр түншээс үзүүлж буй тусламжийн хэмжээ өсч байгаа бөгөөд хамгийн сүүлийн үеийн, бүрэн тоо мэдээллээс үзвэл 2016 онд олон улсын хөгжлийн түншүүд Монгол Улсад 386.6 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийжээ. Эдгээр тусламжийн дийлэнхийг дэд бүтэц, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн салбарын багц төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулсан. Олон улсын валютын тасгаас хэрэгжүүлж буй эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийн дагуу 2017 онд Япон Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар, Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкаас нийт 3 орчим тэрбум ам.долларын нэмэлт тусламжийг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Компакт гэрээ боловсруулах шатанд МСК нь усны салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Азийн хөгжлийн банк, Япон Улсын Засгийн газар болон бусад хандивлагч талуудтай харилцан, мэдээлэл солилцож ажилласан бөгөөд Компакт гэрээг хэрэгжүүлэх шатанд мөн тэрхүү хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийг зорьж байна.

(e) АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА) Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраа 2014 онд хаасан бөгөөд түүнээс хойш АНУ-ын ОУХА нь төсөл хөтөлбөр, төсөв санхүүгийн хувьд Филиппин Улс дахь ОУХА-ийн төлөөлөгчийн газраас удирддаг, үйл ажиллагааны жижиг нэгжийг Монгол Улсад ажиллуулж байна. Одоогийн байдлаар АНУ-ын ОУХА нь ардчилал, засаглалын чиглэлээрх шинэ залуу манлайлагчдад зориулсан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тус байгууллага нь усны салбарт одоогоор санхүүжүүлэн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй бөгөөд цаашид ч мөн хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй юм. АНУ-ын ОУХА-ийн зүгээс усны салбарт үйл ажиллагаа хэрэгжүүлсэн тохиолдолд МСК харилцан уялдаатай ажиллах болно.

(f) Тогтвортой байдал

Төслийн тогтвортой байдлыг хангахад бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, институт, санхүү, байгаль орчин, нийгмийн асуудлууд нэн чухал гэдэгтэй Талууд санал нэгдэж байна. Төслийн өмч хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг зохих ёсоор хийх бөгөөд ингэснээр ус хангамжийн худгуудыг тогтвортой ажиллуулах, ус цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг



хангах бөгөөд Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдохоос сэргийлэх юм. Засгийн газар нь цэвэр, бохир усны тариф, төлбөр болон бусад эх үүсвэрийг ашиглан зардлыг бүрэн нөхөхөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд хөгжингүй орны өндөр туршлага бүхий ус ашиглалтын байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох болон ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулахад нэмэлт туслалцаа үзүүлэх замаар УСУГ-ын чадавхыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд нийгмийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлийг саармагжуулах зорилгоор ус хэрэглэгч харилцан адилгүй бүлгүүдийн устай холбоотой төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа хийх, УСУГ-ын Зардал нөхөх төлөвлөгөөний хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлж, цэвэр, бохир усны үнэ, тарифын бүтцэд тэгш байдлыг харгалзан үзэж тусгахад туслах зэрэг хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Түүнчлэн, тодорхой тооны ус түгээх байранд “ухаалаг” технологи суурилуулахад УСУГ-т дэмжлэг үзүүлэх, гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор УСУГ, нийслэл, дүүргийн харьяа байгууллагуудад гэр хорооллын дэд бүтцийн төлөвлөлт, уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн техникийн туслалцаа үзүүлэх, ус хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглахад УСУГ-т техникийн туслалцаа үзүүлэх, Улаанбаатар хотын усны нөөцийн хомсдолын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөхөд талуудын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх; УСУГ болон Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд холбогдох талуудтай хамтран ажиллахад техникийн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагаа мөн багтсан болно.

(г) Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын шинэчлэл

Засгийн газар нь усны салбарын чухал ач холбогдолтой хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээ, элэгдэл хорогдлыг бүрэн нөхөхүйц цэвэр, бохир усны тариф, хураамжийг нэвтрүүлж, шаардлагатай нэмэлт санхүүжилтийг бусад эх үүсвэрээс гаргахын зэрэгцээ УСУГ-ын Зардал нөхөх төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, баталж, хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд ТЦБ-ийн үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулж буй үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, ангилах ажлыг хэрэгжүүлэхэд Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн, үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэсэн байх шаардлагын биелэлтийг хангах зорилгоор усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай

холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдэд ногдуулах торгууль, хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх тусламжийг Засгийн газарт үзүүлнэ. Түүнчлэн, Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд, боловсруулсан хаягдал ус ашиглахтай бодлогын баримт бичиг, стандартыг шинээр боловсруулах, мөрдүүлэх ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

С. ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Мянганы сорилтын сан-Байгууллага

(а) Бие даасан, хараат бус байдал

Монголын МСС нь үйл ажиллагаа, хууль, эрх зүйн хувьд бие даасан байгууллага байх бөгөөд хараат бусаар шийдвэр гаргах буюу тодруулбал, аливаа этгээдтэй зөвлөлдөж, зөвшөөрөл, баталгаа авалгүйгээр (i) өөрийн нэр дээр гэрээ байгуулах, (ii) шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүхэд өөрийгөө төлөөлөх, (iii) өөрийн нэр дээр санхүүгийн байгууллагад данс нээлгэж, МСК-ын санхүүжилтийг байршуулах, (iv) МСК-ын санхүүжилтийг зарцуулах, (v) гэрээт байгууллага, зөвлөхүүд болон санхүүжилт авч буй этгээд, түүний дотор худалдан авах ажиллагаа хариуцсан төлөөлөгч, санхүүгийн төлөөлөгчтэй хамтран ажиллах, (vi) өөрийн дансанд аудит хийлгэхээр нэг буюу түүнээс олон тооны аудитын байгууллагатай өрсөлдөөний зарчмаар хамтран ажиллах тухай шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй байна. Талууд бичгээр өөрөөр тохироогүй тохиолдолд Монголын МСС-гийн үйл ажиллагааны удирдлага, засаглалын зарчмыг Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, үүсгэн байгуулах баримт бичгүүд болон Монголын МСС-гийн дотоод дүрэм, журамд дэлгэрэнгүй заана.

Монголын МСС-гийн үйл ажиллагааг Удирдах зөвлөл (“Удирдах зөвлөл” гэх) болон Удирдлагын баг (“Удирдлагын баг” гэх) удирдан чиглүүлж, зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

(b) Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь Монголын МСС-гийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих үүрэгтэй зэрэгцээ Монголын МСС-гаас гаргасан аливаа шийдвэр болон Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой хариуцлагыг хүлээнэ. Удирдах зөвлөл нь саналын эрхтэй есөн гишүүн, саналын эрхгүй хоёр ажиллагч гишүүнээс бүрдэнэ. Саналын эрхтэй гишүүд нь энэхүү Компакт гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар дараах байгууллагуудын



төлөөллөөс бүрдэнэ. Үүнд: Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (“БОАЖЯ” гэх), Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Сангийн яам болон Улаанбаатар хотын захиргааны төлөөлөл багтана. Түүнчлэн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хувийн хэвшил, иргэний нийгэм, төрийн бус байгууллагыг төлөөлсөн гурван гишүүн байна. Монголын МСС-г үүсгэн байгуулсан баримт бичиг, дотоод дүрэм, журамд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж, МСК-тай тохиролцсоны дагуу саналын эрх ногдох гишүүд болон тэдгээрийн тоог өөрчилж болно. Эдгээр дотоод дүрэм, журамд Удирдах зөвлөлийн гишүүдийг хэрхэн сонгох тухай тодорхой заана. Монголын МСС-гийн Гүйцэтгэх захирал болон МСК-ын Монгол Улс дахь Суурин захирал нь Удирдах зөвлөлийн саналын эрхгүй ажиглагч гишүүд байна.

(с) Удирдлагын баг

Удирдлагын баг нь үйл ажиллагаагаа Удирдах зөвлөлд тайлагнах бөгөөд Монголын МСС-гийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцна. Удирдлагын багийг Гүйцэтгэх захирал удирдах бөгөөд уг багийг нээлттэй, өрсөлдөөнт, үл ялгаварлах зарчмын дагуу шалгаруулж (эсхүл ийнхүү шалгаруулсантай ижил журмаар) Талуудын зөвшилцөн томилсон захирлууд болон ажилтнуудаас бүрдүүлнэ. Эдгээр захирлуудын удирдлагад зохих тооны мэргэжилтнүүд ажиллаж, Удирдлагын багийг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлөөр хангана. МСК-аас урьдчилан бичгээр мэдэгдсэн тохиолдолд Монголын МСС дахь нэмэлт ажлын байранд ажиллах нэр дэвшигчийг сонгохдоо МСК-аар батлуулна.

Монголын МСС нь олон нийттэй зөвлөлдөх, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудаас санал, зөвлөмж ирүүлж, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор Талуудын оролцоог хангах төлөвлөгөө боловсруулан, баталж ажиллана. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө нь Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандарт 1 буюу Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн удирдлага болон үнэлгээнд тавигдах шаардлагуудыг хангахын зэрэгцээ уг төлөвлөгөөнд багтсан хамтын ажиллагаа, оролцооны арга хэрэгслүүд нь Хэрэгжилт хариуцсан байгууллага, хэрэгжилтийн зохион байгуулалтын тухай МСК-ын зааварчилгаа дахь Оролцогч талуудын хорооны бүтцэд тавигдах шалгууруудыг хангахуйц байвал зохино.

2. Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд.

Засгийн газар нь энэхүү Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон Гэрээтэй холбоотой байгуулсан бусад гэрээний нөхцөл, шаардлагын дагуу аливаа Төсөл, Үйл ажиллагаа (эсхүл тэдгээрийн зарим бүрдэл

хэсэг)-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын харьяа нэг буюу түүнээс олон тооны байгууллага (**“Хэрэгжүүлэгч байгууллага”** гэх)-тай хамтран ажиллаж болно. Хэрэгжүүлэгч байгууллагыг МСК-аас хянан үзэж, зөвшөөрсний дагуу томилж ажиллуулна. Засгийн газар нь Хэрэгжүүлэгч байгууллага тус бүрийн үүрэг, хариуцлага болон холбогдох бусад нөхцөлийг агуулга, хэлбэрийн хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэрээ (**“Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ”** гэх)-нд заасан байна.

3. Санхүүгийн төлөөлөгч.

МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Засгийн газар нь санхүүгийн менежментийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ МСК-ын санхүүжилттэй холбогдуулан санхүүгийн хариуцлагатай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий, санхүүгийн менежментээр мэргэшсэн хувь хүн, байгууллага (**“Санхүүгийн төлөөлөгч”** гэх)-тай хамтран ажиллана. Санхүүгийн төлөөлөгчийн хүлээх үүрэг хариуцлагыг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ болон Засгийн газар, Санхүүгийн төлөөлөгчийн хооронд байгуулах гэрээнд тодорхой заасан байна.

4. Худалдан авах ажиллагааны төлөөлөгч

МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Засгийн газар нь энэхүү Компакт гэрээг хэрэгжүүлэх хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах, баталгаажуулах үүрэг бүхий нэг буюу түүнээс олон тооны Худалдан авах ажиллагааны төлөөлөгч (**“Худалдан авах ажиллагааны төлөөлөгч”** гэх)-тэй хамтран ажиллана. Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, эсхүл Засгийн газар, Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн хооронд байгуулах гэрээнд тодорхой заасан байна. Худалдан авах ажиллагааны төлөөлөгч нь МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаанд заасан хэм хэмжээг дагаж мөрдөх бөгөөд МСК-тай бичгээр өөрөөр тохирсноос бусад тохиолдолд худалдан авах ажиллагааг Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд нийцүүлэн Засгийн газрын боловсруулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллана.



II ХАВСРАЛТ КОМПАКТ ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөний хураангуй (“Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөний хураангуй”) -г II Хавсралтын А Хэсэгт тоймлон харуулав. Засгийн газар нь Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заасан хугацаанд багтан Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, МСК-аас зөвшөөрсний дагуу батална. Уг төлөвлөгөөнд МСК-ын санхүүжилт, Засгийн газраас (шаардлагатай бол) гаргах санхүүгийн болон аливаа бусад эх үүсвэрийн тооцоолж буй хэмжээнээс гадна Хөтөлбөр (захиргааны зардлыг оролцуулан) болон Төсөлд шаардлагатай санхүүжилтийг жилээр болон улирлаар, төсөвлөгдсөн болон тухай бүр шаардлагатай хэмжээнд тулгуурлан тооцож оруулсан байна.

ХАВСРАЛТ II - А ХЭСЭГ КОМПАКТ ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

(сая ам.доллар)									
Бүрэлдэхүүн	Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дэх жил	5 дахь жил	Хөтөлбөрийн нийт зардлын дүн	МУ-ын ЗГ-ын санхүүжүүлэх дүн	МСК-ын санхүүжүүлэх дүн
1. Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл									
(а) Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа	16.00	18.65	26.01	81.60	82.62	73.88	298.76	59.26	239.50
(b) Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа	2.25	12.33	20.04	27.70	23.04	10.34	95.70	52.50	43.20
(c) Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа	2.96	5.18	4.41	4.57	1.98	0.90	20.00		20.00
Хэсгийн дүн	21.21	36.16	50.46	113.87	107.64	85.12	414.46	111.76	302.70
2. Мониторинг, үнэлгээ									



(сая ам.доллар)									
Бүрэлдэхүүн	Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дэх жил	5 дахь жил	Хөтөлбөрийн нийт зардлын дүн	МУ-ын ЗГ-ын санхүүжүүлэх дүн	МСК-ын санхүүжүүлэх дүн
(а) Мониторинг, үнэлгээний зардал	0.03	0.35	3.45	1.79	1.12	3.62	10.36		10.36
Хэсгийн дүн	0.03	0.35	3.45	1.79	1.12	3.62	10.36		10.36
3. Хөтөлбөрийн захиргааны зардал									
(а) Хариуцагч этгээдийн зардал	6.55	3.28	3.34	3.49	3.54	4.93	25.13		25.13
(b) Худалдан авах ажиллагааны болон Санхүүгийн төлөөлөгчдийн зардал	0.03	2.00	2.00	2.00	2.00	2.67	10.70		10.70
(c) Аудитын зардал	0.24	0.16	0.17	0.17	0.18	0.19	1.11		1.11
Хэсгийн дүн	6.82	5.44	5.51	5.66	5.72	7.79	36.94		36.94
ТООЦООЛСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ	28.06	41.95	59.42	121.32	114.48	96.53	461.76	111.76	350.00

III ХАВСРАЛТ КОМПАКТ ГЭРЭЭНИЙ МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ

III Хавсралтад Компакт гэрээний Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний (“Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө”) бүрэлдэхүүн хэсгүүдийг хураангуйлан оруулсан болно. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний бодит агуулга, бүтэц нь уг III Хавсралтад зааснаас ялгаатай байж болох бөгөөд уг төлөвлөгөөг “Компакт гэрээ болон Эрх бүхий орноор шалгарах бэлтгэл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх Мониторинг, үнэлгээний бодлого” (“МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлого”)–ын дагуу Засгийн газар болон МСК-аас харилцан зөвшөөрсөн байна. Түүнчлэн, Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд III Хавсралтад өөрчлөлт оруулалгүйгээр тухай бүр өөрчлөлт оруулж болох бөгөөд ингэхдээ МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод нийцүүлнэ. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө нь МСК-ын цахим хуудаснаа олон нийтэд ил байдлаар нийтлэгдэх бөгөөд өөрчлөлт орсон тухай бүрт шинэчилж байна.



1. Зорилт

Талууд МСК болон Монголын МСС (i) Төсөл зорьсон үр дүндээ хүрэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа эсэхийг хянах (“Мониторинг” гэх), (ii) Компакт гэрээний үр нөлөөг хэмжих, гарсан зардлыг бий болсон үр өгөөжтэй харьцуулах, төслийг хэрэгжүүлэхэд баримталсан стратеги, хэрэгжилтээс авсан сургамж зэргийг үнэлэх (“Үнэлгээ” гэх) ажлыг юунд чиглүүлж, хэрхэн гүйцэтгэх талаар дэлгэрэнгүй заасан Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулахаар харилцан зөвшөөрч, Засгийн газар нь уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх буюу хэрэгжих нөхцөлөөр хангахаар тохирсон болно. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө нь МСК-д тогтмол тайлагнах бүх үзүүлэлтүүд болон Хөтөлбөрийн үнэлгээнд зориулж цуглуулах аливаа нэмэлт мэдээлэл, тэдгээрийн тайлбарыг агуулсан байна. Түүнчлэн, Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд Монголын МСС санхүүжилт авахын тулд биелүүлсэн байх мониторинг, үнэлгээний шаардлагуудыг мөн тусгах бөгөөд уг төлөвлөгөө нь Монголын МСС-гийн ажилтнууд болон холбогдох бусад талууд Монголын МСС-гийн дэвшүүлж буй зорилтууд, хүрэх ёстой түвшинг тодорхой ойлгоход ашиглах харилцаа холбооны хэрэгслийн үүргийг гүйцэтгэнэ. Мониторинг, үнэлгээний үйл ажиллагааны үр дүнг хэмжихдээ холбогдох тоо баримтыг хянаж үзэх, үнэлэх аргыг ашиглах бөгөөд ийнхүү хэмжсэн үр дүнг Монголын МСС болон МСК-ын цахим хуудаст олон нийтэд ил байдлаар нийтэлсэн байна.

2. Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдаа

Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдаа гэдэг нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ Компакт гэрээний зорилго, зорилт болон хүлээгдэж буй үр дүнтэй хэрхэн уялдаж буйг тайлбарлан харуулсан загвар юм. Энэхүү загварт Хөтөлбөрийн агуулга, хэрэгжилтийн төлөвлөгөөг тусгахын зэрэгцээ төлөвлөж буй үйл ажиллагаа, тэдгээрээс гарах үр дүнг эрэмбэ дарааллын дагуу тэмдэглэсэн байна. Түүнчлэн, Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдааны хүрээнд эдийн засгийн өгөөж (“ЭЗӨ” гэх)-ийг тооцдог зардал-үр өгөөжийн шинжилгээний суурь болох эдийн засгийн уялдаа холбоог мөн авч үзсэн. Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдаа нь төлөвлөж буй үр дүнд хүрэхтэй холбоотой болзошгүй эрсдэл болон тооцооллыг агуулах бөгөөд цаашид Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах суурь болох юм.

2.1 Логик загвар

Засгийн газар нь Төслийн зорилтод хүрэхийн тулд Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд дэд бүтцийн хэд хэдэн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлнэ.

Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаанаас гарах бодит үр дүн нь Биокомбинат болон Шувуун фабрик орчмын эх үүсвэрүүдэд шинээр худгууд байгуулагдаж, тэдгээр худгаас олборлосон усыг гүн цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий байгууламж шахуургын станц, цуглуулах шугам хоолой, ус нөөцлөх сан, дамжуулах шугамууд зэрэг дагалдах дэд бүтцийн хамт байгуулагдсан байх явдал юм. Харин энэхүү бодит ажлыг гүйцэтгэснээр гарах хүлээгдэж буй үр дүн нь газрын доорх усны давхаргаас олборлож, Улаанбаатар хотод нийлүүлж буй, улмаар унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын хэрэглэж буй усны хэмжээ нэмэгдэх явдал болно. Ус хангамжийг эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй эх үүсвэрээс нэмэгдүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломж өргөжиж, улмаар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд ус дахин боловсруулах үйлдвэр, шахуургын станц, дамжуулах шугам хоолой болон ДЦС-3 болон ДЦС-4 дээр ус нөөцлөх хэд хэдэн усан сан, дотоод хяналтын хавхлага зэргийг барьж байгуулна. Энэ ажлыг гүйцэтгэснээр хүрэх хүлээгдэж буй үр дүн нь ДЦС-3, ДЦС-4-ийн эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн зарим үе шатанд дахин боловсруулсан усыг тогтмол нийлүүлэх юм. Ингэснээр станцуудын гүний худгуудаас олборлодог газрын доорх усыг дахин боловсруулсан усаар орлуулах боломж бүрдэж, тэдгээр чөлөөлөгдсөн эх үүсвэрээс Улаанбаатар хотын унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын хэрэглээнд зориулан нийлүүлэх усны хангамжийг нэмэгдүүлнэ. Ус хангамжийг эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй эх үүсвэрээс нэмэгдүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломж өргөжиж, улмаар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах юм.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаанаас гарах бодит үр дүн илүү олон төрөлтэй. Зардал нөхөх дэд үйл ажиллагаа болон Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа нь хамтдаа УСУГ-ын орлогыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын гэр хороололд ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд гардаг өндөр зардлыг бууруулах гэсэн бодит үр дүнд хүрэхийг зорьж байгаа. Харин эдгээр бодит үр дүн нь зардлаа бүрэн нөхөхүйц цэвэр, бохир усны тарифыг нэвтрүүлэх гэсэн хүлээгдэж буй үр дүнд чиглэгдэнэ. Зардал нөхөх тарифыг нэвтрүүлснээр ус ашиглалтын байгууллагад үйл ажиллагаа болон засвар үйлчилгээгээ бүрэн төсөвлөж, хэрэгжүүлэх боломжийг олгох бөгөөд ингэснээр баруун эх үүсвэрт шинээр байгуулах худгуудыг өндөр үр ашигтайгаар ажиллуулах, улмаар газрын доорх ус олборлох дэд бүтцийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах нөхцөл бүрдэнэ. Үүний нэгэн адил, Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагааны




хүрээнд шинэ байгууламжуудыг ашиглах, үндсэн хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг төлөвлөх, гүйцэтгэхэд шаардлагатай чадавхыг УСУГ-т бий болгох ажлууд хийгдэнэ. Ингэснээр шинэ үндсэн хөрөнгийг ашиглах, засвар үйлчилгээ гүйцэтгэх чадвар сайжирч, баруун эх үүсвэрт шинээр байгуулах худгуудыг өндөр үр ашигтайгаар ажиллуулах, улмаар газрын доорх ус олборлох дэд бүтцийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах нөхцөл бүрдэнэ.

Олон нийтийг мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, зан үйлийг өөрчлөх үйл ажиллагааны хүрээнд ус хангамж, ус хангамжийн үйлчилгээтэй холбоотой нийт өртөг зардлын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, УСУГ, Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар (ОСНААУГ) болон үйлчилгээний бусад байгууллагуудтай холбогдож, санал хүсэлтээ дамжуулах сувгуудыг таниулах, улмаар цэвэр, бохир усны тарифыг өөрчлөхөд олон нийтийн дэмжлэгийг авах суурийг тавина. Үүний зэрэгцээ Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагааны хүрээнд гадаргын болон газрын доорх усны чанарыг хадгалах, холбогдох стандартыг мөрдүүлэхэд БОАЖЯ-д туслалцаа үзүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлнэ. Энэ ажил нь Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааг шууд дэмжих бөгөөд аажимдаа шинээр баригдах худгуудаас олборлож, Улаанбаатар хотод нийлүүлж буй, улмаар унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын хэрэглэж буй усны хэмжээ нэмэгдэх гэсэн үр дүнд хүрнэ. Ус хангамжийг эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй эх үүсвэрээс нэмэгдүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломж өргөжиж, улмаар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах юм.



Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдаа





2.2 Эрсдэл, Төсөөлөл

Хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдаагаар тоймлон харуулсан хүлээгдэж буй үр дүнд хүрэх явцад үүсч болзошгүй эрсдэлүүд болон төсөөллийг Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд тусгана. Гэхдээ холбогдох Талаас энэ асуудлыг тухайлан зааж, бичгээр хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр эрсдэл, төсөөлөл нь нөгөө Талын ажлын гүйцэтгэл хангалтгүй байгааг тайлбарлах хүчин зүйл болж чадахгүй болно. Одоогоор мэдэгдэж буй эрсдэл болон төсөөллийг дор авч үзэв. Үүнд:

(а) Дээд эх үүсвэрийн уст давхарга, хувийн худгууд болон бусад эх үүсвэрээс олборлон нийлүүлж буй усны хэмжээ нэмэгдэхгүй (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Байхгүй)

(b) Орлого болоогүй усны түвшин тогтвортой байх (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Байхгүй)

(с) Бодит эрэлтийн хэмжээ МСК-ын тооцоолсонтой дүйцэхүйц өндөр байх (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Байхгүй)

(d) ДЦС-уудын ашиглаж байсан худгуудыг УСУГ-ын ашиглалтад шилжүүлэх холболтууд хийгдэнэ (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Компакт гэрээ хэрэгжих хугацаанд худгуудыг УСУГ-ын харьяанд шилжүүлэх, эсхүл тэдгээр худгаас олборлох усыг ашиглаж эхлэх цаг хугацааны тодорхой төлөвлөгөө гаргах. Шаардлагатай бол удирдлагын түвшинд уулзалтууд зохион байгуулж, ДЦС-3 болон ДЦС-4-өөс чөлөөлөх газрын доорх усны нөөцийг Нийслэлийн унд, ахуйн усны хэрэгцээнд ашиглахын ач холбогдлыг дахин баталгаажуулах,

(e) ДЦС-3 болон ДЦС-4 гүний худгуудаа чөлөөлж, УСУГ-ын шугам сүлжээнд холбуулах (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Дээрх (d) хэсэгтэй адил)

(f) Шинэ ТЦБ-ийг байгуулж, чанарын шаардлага хангасан хаягдал усыг Бохир ус дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх (Нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Компакт гэрээ хүчин төгөлдөр болохын өмнө ТЦБ-ийн барилга угсралтын ажил эхэлсэн байх урьдчилсан болзолт нөхцөл тавигдаж байгаа бөгөөд Гэрээний санхүүжилтээс зарцуулах бүрт тэрхүү барилга угсралтын ажилд ахиц гарсан байх нөхцөл тавигдана. Түүнчлэн Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход тавигдах нэг урьдчилсан болзолт нөхцөл нь үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний шаардлагуудыг боловсруулсан байх явдал юм) зэрэг багтана.

Энэхүү Төслийн урт хугацааны нэгэн чухал үр дүн нь Улаанбаатар хотын аж үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг бий болгох явдал юм. Гэхдээ энэхүү өсөлтөд Хөтөлбөрийн хөрөнгө оруулалттай шууд хамааралгүй хийгээд хөрөнгө оруулалтын шууд үр дүн бус олон янзын хүчин зүйлс нөлөөлөх тул Төслийн хүрээнд гарах тодорхой үр дүн болон илүү урт хугацааны үр нөлөө хоорондын шалтгаант холбоог баттай тогтооход төвөгтэй юм.

2.3 Тооцоолж буй эдийн засгийн үр өгөөж, үр өгөөжид хамрагдах бүлэг

Засгийн газар болон МСК хамтран Төслийн хүрээнд хийх хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлыг тооцох зорилгоор эдийн засгийн дүн шинжилгээ хийсэн. Хөтөлбөрт хийсэн эдийн засгийн шинжилгээ нь төслийн эдийн засгийн өгөөжийг тооцдог зардал-үр өгөөжийн шинжилгээ (“ЗҮӨШ” гэх) болон төслийн үр өгөөжид хамрагдагсдын шинжилгээнээс бүрдэнэ. Хөтөлбөрийн эдийн засгийн шинжилгээг доор тоймлон оруулав.

2.3.1 Тооцоолж буй эдийн засгийн үр өгөөж

Зардал-үр өгөөжийн шинжилгээгээр Төслийн болон Төслийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж дууссанаас хойшх 30 жилийн хугацаанд бий болохоор хүлээгдэж буй эдийн засгийн нийт үр өгөөжийг тооцсон бөгөөд ингэхдээ Төсөл, үйл ажиллагааны зардлыг Компакт гэрээ, эсхүл бусад эх үүсвэрээс санхүүжиж байгаагаас үл хамааран бүхэлд нь авч үзсэн. Зардал-үр өгөөжийн шинжилгээнд ашигласан загварын суурь болох эдийн засгийн логик уялдаа нь энэхүү хавсралтын 2.1 дэх хэсэгт тодорхойлсон Төслийн логик уялдаанд тулгуурласан бөгөөд уг эдийн засгийн загварт ашигласан хувьсагчдыг Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Төслийн хэрэгжилтэд мониторинг хийх, хүлээгдэж буй үр дүнгийн гүйцэтгэлийг хянах, цаашилбал хөрөнгө оруулалт үр ашигтай байсан эсэхийг хэмжих үзүүлэлт болгон ашиглана.

МСК хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа төсөл тус бүр дээр тооцоолж буй эдийн засгийн өгөөж арван хувиас багагүй байх босгыг тавьдаг. Олдож болох хамгийн бүрэн, найдвартай мэдээлэл, судалгаан дээр үндэслэн МСК нь Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн нийт эдийн засгийн өгөөж 10.9% байхаар тооцоолсон. Энэ үзүүлэлтийг хэрхэн гаргасан, ямар тоон мэдээлэл ашигласан талаар болон холбогдох нэмэлт мэдээллийг МСК-ын цахим хуудаснаас авах боломжтой.

Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн үндсэн үр өгөөж нь Улаанбаатар хотын ус хангамжийн системд нийлүүлэх нэмэлт уснаас үүдэн гарна. Газрын доорх усны баруун эх үүсвэрт шинээр худгууд гаргаж,



гүн цэвэршүүлэх үйлдвэрийг ус дамжуулах шугам сүлжээний хамт барьж байгуулснаар Улаанбаатар хотын усны хэрэгцээнд нэмж 50 сая м³/жил ус нийлүүлэх боломжтой болно.

Ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд ДЦС-3, ДЦС-4-ийн одоо хэрэглэж буй цэвэр усыг дахин боловсруулсан усаар орлуулснаар цаашид 14.6 сая м³/жил усыг нэмж нийлүүлэх боломж үүснэ. Ингэж орлуулсны үр өгөөжийн дийлэнх хэсэг нь харьцангуй жожуу буюу баруун эх үүсвэрийн бохирдлын түвшин буурч, ДЦС-ууд одоо ашиглаж байгаа худгуудаа хотын хэрэглээний ус хангамжид зориулан шилжүүлэх үед бий болох юм. Ус хангамж ийнхүү нэмэгдсэнээр унд ахуйн ус хэрэглэгчдийн амьдралын ерөнхий чанар дээшлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний гарц нэмэгдэх боломжтой хэмээн үзэж байна.

Компакт гэрээг хэрэгжүүлснээр бий болох нэмэлт усгүйгээр унд ахуйн хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчид ирэх 3-4 жилийн дотор усны хомсдолын үр дагаврыг мэдэрч эхлэхээр байгаа. Усны үнэ өсөхийн хэрээр нэмэлт усанд төлбөр төлж, хэрэглэх хэрэглэгчдийн эрмэлзэл нь тэдний эрэлтийн мэдрэг чанараас шалтгаалан харилцан адилгүй байж болох бөгөөд усны бодит үнэ цэнэ илүү тод томруун мэдэгдэх болно.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа нь Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа болон Ус дахин боловсруулах үйл ажиллагааны дүнд бий болсон нэмэлт усны нийлүүлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах юм. УСУГ-ын одоо ашиглаж буй дээд эх үүсвэрүүдийн үйл ажиллагаа сүүлийн арав гаруй жилийн хугацаанд мэдэгдэхүйц муудаж байгаа талаар баримт мэдээлэл бий бөгөөд тэдгээрээс үзэхэд энэхүү арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай нь харагдаж байна. Тарифыг өсгөж, засвар үйлчилгээний төлөвлөлтийг оновчтой болгох, дэд бүтцийг сайжруулах замаар зардлыг бууруулснаар УСУГ-т үндсэн хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг урт хугацаанд сайжруулах, улмаар эх үүсвэрүүдийн доройтлыг сааруулах боломж бий болох юм.

2.3.2 Хөтөлбөрийн үр өгөөжид хамрагдах бүлэг

Хөтөлбөрөөс үр өгөөж хүртэх хувь хүн болон байгууллагагч Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд тодорхой заасан байна. Үр өгөөжид хамрагдагсдын шинжилгээ нь Зардал-үр өгөөжийн шинжилгээний нэг хэсэг бөгөөд нийгмийн чухам аль хэсэг төслөөс үр өгөөж хүртэх вэ гэдгийг нарийвчлан тодорхойлохын тулд Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бий болсон нийт орлогын өсөлтийг түүний түвшин бүрээр нарийвчлан гаргадаг. МСК

нь төсөл, үйл ажиллагааны үр дүнд бодит орлого нь нэмэгдэж, улмаар амьжиргааны түвшин нь дээшилсэн хүмүүсийг төслийн үр өгөөжид хамрагдах бүлэг гэж үздэг.¹ Тодорхойлолтыг илүү оновчтой байлгах үүднээс, МСК-ын төсөлд оролцогсдыг хөтөлбөрийн үр өгөөжид хамрагдах бүлэгт нийтээр нь хамруулж үздэггүй болохыг дурдах нь зүйтэй. Ирэх 30 жил (өөрөөр заагаагүй бол)-ийн хугацаанд энэхүү Компакт гэрээний үр өгөөжид хамрагдагсдын тоог дараах хүснэгтэд харуулсан бөгөөд хүснэгтийн дор тэдгээрийн талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

Хөтөлбөр	Үр өгөөжид хамрагдагсдын тоо /тооцоолж буйгаар/
Ус хангамжийг нэмэгдүүлэх	2,427,657

Газрын доор усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа, Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа болон Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлнэ. Тиймээс эдгээр үйл ажиллагааны үр өгөөжид хамрагдагсад нь Улаанбаатар хотын нийт хүн ам байна.

Хүртэх үр өгөөжийн хуваарилалт нь хэрэглэгчийн төлбөр төлөх эрмэлзэл болон усны хэрэглээний түвшнээс хамаарч харилцан адилгүй байна. Хэдийгээр өрх тус бүрийн усны хэрэглээг нарийвчлан гаргах боломжгүй ч айл өрх, байгууллагуудын ангилал тус бүрийн хэрэглэдэг усны хэмжээ мэдэгдэж байгаа бөгөөд харилцан адилгүй ангиллын өрхүүдийн дунд эзлэх ядуу өрхийн хувь хэмжээ ч мөн мэдэгдэж буй. Иймд энэ мэдээлэл дээр үндэслэн амьжиргааны доод түвшний хэрэглэгчдэд хүрэх төслийн үр өгөөжийн хувийг тооцоолсон болно.

Монгол Улсад ядуурлын түвшин тогтооход баримталдаг шугам буюу хоногийн 2.57 ам.доллараас бага орлоготой хэсэгт Компакт гэрээний нийт үр өгөөжийн 7.4% ногдох бөгөөд энэ нь өмнө дурдсан ядуурлын шугамын доод хэсэгт харьяалагдах иргэний жилийн дундаж орлогын 13%-тай дүйцэх үр өгөөжийг 30 жилийн туршид хүртэнэ гэсэн үг юм.

3. Мониторинг

МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод тодорхойлсноор, мониторинг гэдэг нь тавьсан зорилтуудаа биелүүлэх хугацаанд гарч буй ахиц болон тэр хүртэл дэвшүүлсэн явцын үр дүнд хүрч буй эсэхийг хэмжихээр тусгайлан сонгож авсан үзүүлэлтүүдийн дагуу холбогдох мэдээллийг системтэйгээр, байнга цуглуулах үйл ажиллагаа юм.

¹Энэхүү Компакт гэрээнд ашигласан “үр өгөөж хүртэгч” гэсэн ойлголтыг МСК-ын Эдийн засгийн болон үр өгөөж хүртэгчдийн шинжилгээ хийх заавар-т тодорхойлсноор ойлгоно.



Энэхүү Компакт гэрээ зорьсон үр дүндээ хүрч байгаа эсэхийг хянахын тулд Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний Мониторингийн хэсэгт дараах зүйлсийг хамруулсан байна. Үүнд: (i) хяналтад ашиглах Үзүүлэлтүүд (дор тодорхойлсон), (ii) Үзүүлэлтүүдийн тодорхойлолт, (iii) Үзүүлэлтүүдийн дагуу тоон мэдээлэл цуглуулах арга, эх сурвалж, (iv) мэдээлэл цуглуулах давтамж, (v) мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг тус тус хариуцагч этгээд, (vi) Үзүүлэлт тус бүрийг МСК-д тайлагнахад баримтлах хугацаа зэрэг болно. Шаардлагатай тохиолдолд, Компакт гэрээ хэрэгжиж дууссаны дараа ч зарим Үзүүлэлтийг үргэлжлүүлэн хянах юм.

3.1 Зорилго, Үр дүн, Гарц, Явцын үзүүлэлтүүд.

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөгөөр Хөтөлбөрийн үр дүнг хэмжихдээ хэмжигдэхүйц, бодитой, найдвартай тоон болон бусад мэдээлэл (“Үзүүлэлт” гэх)-ийг ашиглана.

(a) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд бүх үзүүлэлтийн суурь утга (“Суурь утга” гэх)-ыг тогтооно. Аливаа Үзүүлэлтийн суурь утгыг холбогдох Төсөл, Үйл ажиллагаа, Дэд үйл ажиллагаа эхлэхээс өмнө тодорхойлсон байна. Суурь утга нь тулгамдаж буй асуудлыг хэмжигдэхүйц байдлаар илэрхийлдэг тул тухайн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохих ёсоор төлөвлөх суурь болдог юм. Засгийн газар нь зарим тодорхой Үзүүлэлтийн суурь утгыг цуглуулах, эсхүл өмнө цуглуулсан суурь утгыг нягтлан баталгаажуулах үүргийг хүлээнэ.

(b) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд Үзүүлэлт тус бүрийн харьцуулах түвшинг тухайн үр дүн гарсан байх хугацаа, үзүүлэлтийн авах утгын хамт тусгана. (“Зорилтот түвшин” гэх)

(c) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд чухам аль Үзүүлэлт нь хүйс, орлогын түвшин, нас болон үр өгөөжид хамрагдагсдын төрлөөр задарсан байхыг тухайлан заах бөгөөд ингэхдээ тухайн Үзүүлэлтээр задаргаа хийгдэх боломж, шаардлагыг харгалзан үзнэ.

(d) “Зорилгын үзүүлэлт” нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжсэний дараа бий болох эдийн засгийн өсөлт, ядуурлын түвшинд гарсан бууралтыг хэмжих бөгөөд ингэхдээ ихэнх тохиолдолд дотоодын орлогыг шууд хэмждэг. МСК-ын бүх Компакт гэрээнд Зорилгын үзүүлэлтийг хэмжихээр заадаг тул доорх хүснэгтэд тусгайлан оруулаагүй болно.

(e) Үр дүн, гарц, явцын үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод оруулсан байдаг.

(f) МСК-ын “Нийтлэг үзүүлэлтүүд” (МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод тодорхойлсноор)-ээс холбогдох хэсэг нь мөн энд орно.

(g) МСК-аас бичгээр зөвшөөрсний дагуу Засгийн газар нь МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод нийцүүлэн шинээр Үзүүлэлт нэмэх, эсхүл ашиглаж буй Үзүүлэлтийн тодорхойлолт, зорилтот түвшинд өөрчлөлт оруулж болно.

(h) Монголын МСС нь МСК-аас өгөх “Үзүүлэлт хянах хүснэгт”-ийг ашиглан Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд багтсан Үзүүлэлтүүдийн мониторингийн үр дүнг улирал бүр МСК-д тайлагнана. Энэхүү хүснэгт дэх Үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь утга, зорилтот түвшинг эхлээд Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд тусгаж батлалгүйгээр өөрчилж болохгүй. Үзүүлэлтүүдийг тайлагнахдаа Тайлан гаргах зааварчилгааны холбогдох заалтуудыг мөн баримтална. Монголын МСС зургаан сарын хугацааг хамарсан санхүүжилтийн хүсэлт гаргасан тохиолдолд ч Үзүүлэлт хянах хүснэгтийг улирал бүр мөн ёсоор хүргүүлнэ.

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө нь Хүснэгт 1-т жагсаасан мониторингийн Үзүүлэлтүүдийг агуулсан байна.

4. Үнэлгээ

Хөтөлбөрийн мониторингийг чанартай хэрэгжүүлэх нь хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад чухал шаардлагатай ч, эцсийн үр дүнг хэмжихэд дангаараа хангалтгүй юм. Тиймээс МСК нь тухайн Хөтөлбөр дэвшүүлсэн үр дүндээ хүрсэн эсэх талаар илүү сайн ойлголттой болохын тулд харилцан адилгүй хэд хэдэн аргаар үнэлгээ хийхийг зөвлөмж болгодог. МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод тодорхойлсноор Үнэлгээ гэдэг нь хөтөлбөрийн бүтэц, хэрэгжилт, үр дүнг бодитой, системтэй байдлаар дүгнэн шинжлэх үйл явц юм. МСК нь зардлын үр ашигт байдлыг үнэлэх, хүлээсэн үр дүнд хүрэхэд тухайн Хөтөлбөрийн үзүүлсэн нөлөөллийн хэмжээг тогтоохын тулд Үнэлгээгээ аль болох нарийвчилсан байдлаар хийхийг зорьдог. Тухайн төслийн онцлогоос шалтгаалан Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний Үнэлгээний хэсэгт дараах гурван төрлийн ажиллагаанаас сонгон оруулдаг. Үүнд: (i) бие даасан үнэлгээ (нөлөөлөл болон/эсхүл гүйцэтгэлийн үнэлгээ); (ii) өөрийгөө үнэлэх үнэлгээ, (iii) тусгайлсан судалгаа багтах бөгөөд тус бүрийг нь МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

(a) Бие даасан үнэлгээ. Төсөл бүрт иж бүрэн, бие даасан үнэлгээ (нөлөөлөл болон/эсхүл гүйцэтгэлийн үнэлгээ)-г МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогод нийцүүлэн хийх ёстой. Мониторинг, үнэлгээний



төлөвлөгөөний Үнэлгээний хэсэгт үнэлгээний зорилго, арга зүй, цаг хугацаа, МСК-аас авах зөвшөөрлүүд, шаардлагатай мэдээллийг цуглуулах, шинжилгээ хийх үйл явцыг тодорхойлсон байна. Бүх бие даасан үнэлгээг хараат бус, хөндлөнгийн этгээд төлөвлөж, гүйцэтгэх ёстой. Засгийн газар хөндлөнгийн аливаа этгээдээр үнэлгээ хийлгэх саналтай байгаа тохиолдолд МСК-аас бичгээр урьдчилан зөвшөөрөл авсан байна. Үнэлгээ хийх гэрээний нөхцөлийг МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд үнэлгээний үр дүн аливаа нөлөөллөөс ангид байж, олон нийтэд хэвлэн хүргэх нөхцөлийг хангасан байх ёстой.

Бие даасан үнэлгээ тус бүрийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нягтлах, үнэлгээний эцсийн тайлан арга зүй болоод баримт нотолгооны хувьд үнэн зөв байх нөхцөлийг хангахын тулд Монголын МСС нь хараат бус үнэлгээ хийх төлөвлөгөөний бүтэц, ашиглах материал (үүнд, асуулгын хуудас мөн багтана), суурь нөхцөлийн тайлан (байгаа бол) болон явцын болон эцсийн бусад тайланг хянан үзэж, санал зөвлөмжөө өгч ажиллана.

Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл: Энэхүү Төсөлд хийх Үнэлгээ нь гүйцэтгэлийн үнэлгээ байх бөгөөд тоон мэдээлэл цуглуулж, ашиглана. Үнэлгээний эхэнд төслийн хэрэгжилтийн судалгаа хийж, төслийн хэрэгжилт анх гаргасан төлөвлөгөөний дагуу явагдсан эсэхийг үнэлдэг. Улмаар энэхүү судалгааны үр дүнг хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн логик уялдааны дараагийн шатны үр дүнг үнэлэхэд ашиглах болно. Төслийн үр дүнгээс үүдэн гарсан байж болзошгүй нөлөөллийг үнэлэхийн тулд усны нийлүүлэлт, хэрэглээний олон жилийн тоон мэдээллийг ашиглах бөгөөд ингэхдээ усны хэрэглээ болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц зэрэгт үзүүлсэн байж болох ерөнхий нөлөөллийн түвшинг нарийн тодорхойлохын тулд айл өрх болон аж ахуйн нэгжүүдээс судалгаа авах юм.

Төслийн бүтэц, агуулгад үндэслэн МСК болон Засгийн газар нь үнэлгээний асуултуудыг эцэслэн тохирох бөгөөд Төслийн үнэлгээ нь дараах асуултуудад хариулт авах зорилготой байна. Үүнд:

- Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл Улаанбаатар хотын усны өсөн нэмэгдэх эрэлтийг хангасан уу? Энэ асуулт нь [Нэмэлт эрэлт хангагдсан эсэх] гэх үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой.
- Тийм бол, төсөл хэрэгжээгүй гэсэн хийсвэр нөхцөл байдалтай харьцуулахад (эсрэг нөхцөл байдал) Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын усны хэрэглээг нэмэгдүүлсэн үү? Энэхүү нэмэлт хэрэглээ нь гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчдэд ямар үр өгөөжийг бий болгож, тэр нь хэрэглэгчдийн орлогын түвшнээр ямар ялгаатайгаар

ногдож байна вэ? Энэ асуулт нь [Улаанбаатар хотын унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын хэрэглэсэн нэмэлт ус] гэх үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой.

- Хэрэв төсөл хэрэгжээгүй гэсэн хийсвэр нөхцөл байдалтай харьцуулахад (эсрэг нөхцөл байдал), энэхүү төсөл хэрэгжсэнээр унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын усны хэрэглээ нэмэгдсэн бол усны өссөн хэрэглээ нь тухайн байгууллагын бүтээгдэхүүний гарц болон ашгийг нэмэгдүүлсэн эсэх? Энэ асуулт нь [Ус ашигладаг аж үйлдвэрийн салбарын гарцын өсөлт, Ус ашигладаг аж үйлдвэрийн салбарын ашгийн өсөлт] гэх зорилгын үзүүлэлттэй холбоотой.
- УСУГ Туул голын бохирдлын түвшин буурснаар болон баруун эх үүсвэрийн уст давхаргын усыг цэвэршүүлснээр бий болох эерэг нөлөөллийг хадгалах үүднээс усны чанарын стандартын хяналтыг тогтмол хийж байгаа эсэх? Энэ асуулт нь [МСК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулсан эх үүсвэрээс гаргаж авсан усны хэмжээ] гэх үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой.
- Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа нь ДЦС-ууд ашиглаж байсан хугацаагаар УСУГ-т шилжүүлэх, улмаар Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж буй эсэх? Энэ асуулт нь [Усны ерөнхий хэрэглээнд зориулж чөлөөлсөн газрын гүний ус] гэх үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой.
- Ус хангамжийн төслийн эдгээр үр дүн цаашид тогтвортой хадгалагдах эсэх? Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэх усны эрэлт цаашид хангагдаж чадах эсэх? УСУГ-ын үйл ажиллагаа, засвар үйлчилгээ нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол Компакт гэрээ хэрэгжихээс өмнөх түвшинд буцаж хүрэхээс сэргийлэх хэмжээнд хэрэгжиж байгаа эсэх? Усны тарифын өөрчлөлтүүд өртгөө бүрэн нөхөх хэмжээнд байгаа эсэх? Зохицуулагч байгууллага хараат бусаар ажиллаж, бусад сайн жишгийн дагуу салбарын стандарт болон тарифыг тогтоон, тогтмол мөрдүүлж ажиллаж байгаа эсэх? Тарифын шатлал нь Засгийн газрын нийгмийн хамгааллын бодлогод нийцүүлэн ядуу өрхүүдийг дэмжиж байгаа эсэх? Эдгээр нь Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны үр дүн мөн эсэх? Эдгээр асуулт нь [УСУГ-ын худгийн хүчин чадлын жил тутмын доройтол багассан байдал, Зардал туссан тариф мөрдөгдсөн эсэх] гэх үр дүнгийн үзүүлэлттэй холбогдоно.



Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө нь Хүснэгт 1–г заасан үнэлгээний Үзүүлэлтүүдийг агуулсан байна.

(b) Өөрийгөө үнэлэх үнэлгээ. Компакт гэрээний хугацаа дууссаны дараа МСК болон Монголын МСС нь тус тус дараах гурван үндсэн асуултын дагуу иж бүрэн үнэлгээ хийнэ. Үүнд, (i) Төсөл тавьсан зорилтдоо хүрсэн үү? (ii) Ямар учраас төсөл тавьсан зорилтдоо хүрсэн, эсхүл хүрээгүй вэ? (iii) Төслийн хэрэгжилтээс ямар сургамж, туршлага (үйл явцын болон агуулгын хувьд) авсан бэ? Монголын МСС-гийн ажилтнууд эдгээр үндсэн асуултауд болон Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой бусад асуудлуудыг үнэлж дүгнэн, Компакт гэрээний хэрэгжилтийн сүүлийн жил Компакт гэрээний хаалтын тайлангийн төслийг боловсруулна. Монголын МСС-гийн нэгж, хэлтэс бүр тус тусын чиглэлээр Компакт гэрээний хаалтын тайланд багтах хэсгүүдийг боловсруулж, бусад нэгж, хэлтсүүдээр хянуулна. Монголын МСС Компакт гэрээний хаалтын тайлангийн төслийг бэлтгэсний дараа МСК-ын холбогдох ажилтнууд мөн Компакт гэрээний гүйцэтгэлийн тоймыг бэлтгэнэ. Компакт гэрээний хаалтын тайлангийн адилаар МСК-ын нэгж, хэлтэс бүр хариуцсан чиглэлээр тайлан гаргах бөгөөд бусад нэгж хэлтсүүдээр мөн хянуулна.

(c) Тусгайлсан судалгаа. Монголын МСС, МСК хамтран Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг батлахын өмнө Тусгайлсан судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулан тогтсон байна. Тусгайлсан судалгаанууд, тухай бүр хийгдэх онцгой үнэлгээнүүд болон Компакт гэрээний мониторинг, үнэлгээний хүрээнд хийгдэх бусад судалгааг Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд тодорхойлж, холбогдох заалтуудыг тусгасан байна. МСК болон Засгийн газрын аль аль нь Компакт гэрээний хугацаа дуусахаас өмнө Төсөл, аливаа Үйл ажиллагаа, эсхүл Хөтөлбөрийн хэрэгжилттэй бүхэлд нь холбогдуулан тусгайлсан судалгаа, эсхүл тухай бүрт хийгдэх онцгой үнэлгээ хийх хүсэлт гаргаж болно. МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогын дагуу бүх үнэлгээний үр дүн нь олон нийтэд нээлттэй байна.

5. Мэдээллийн чанарын хяналт

Мэдээллийн чанарын хяналт гэдэг нь мэдээллийн бүрэн бүтэн байдал, бодитой байдал, ашиглахад хялбар байдлыг нягтлах үйл ажиллагаа юм. Мэдээллийн чанарын хяналт нь (a) мэдээллийн чанар, (b) мэдээлэл цуглуулах хэрэгсэл, (c) судалгааны түүвэрлэлтийн арга, (d) мэдээлэл цуглуулах ажиллагаа, (e) мэдээллийг шивэх, хадгалах, хуулах ажиллагаа, (f) мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх ажиллагаа, (g) мэдээллийг түгээх ажиллагааг хамарна. Хөтөлбөр, Төслийн хэмжээнээс хамааран МСК нь дотоодын буюу олон улсын мэргэшсэн пүүс, судалгааны байгууллага, эсхүл зөвлөх хувь хүн зэрэг хараат бус этгээдээр Мэдээллийн

чанарын хяналтыг хийлгэх шаардлага тавьдаг. Мэдээллийн чанарын хяналтын давтамж, хугацааг Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд тодорхой заасан байх ч, МСК нь энэхүү хяналтыг хийлгэх хүсэлтийг хэдий ч тавьж болно. Мэдээллийн чанарын хяналтыг Компакт гэрээний хугацаа дуусахаас зохих хугацааны өмнө буюу (шаардлагатай бол) хяналтын үр дүнд үндэслэн арга хэмжээ авахад хангалттай хугацаа үлдсэн байхаар төлөвлөж хийнэ. Мэдээллийн чанарын хяналт хийх аргачлал нь бичиг баримт, тайланг нягтлан үзэх, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, мэдээлэл өгсөн гол этгээдүүдтэй ярилцлага хийх, сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах зэргээс бүрдэнэ.

6. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний бусад бүрэлдэхүүн хэсгүүд

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө нь мониторингийн болон үнэлгээний хэсгээс гадна дараах хэсгийг мөн агуулсан байна. Үүнд:

(a) Мэдээллийн удирдлагын систем. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд холбогдох мэдээллийг цуглуулах, хадгалах, боловсруулах, тэдгээрийг оролцогч талуудад хүргэхэд ашиглах мэдээллийн системийг заасан байх бөгөөд энэхүү систем нь Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний дагуу цуглуулж, баталгаажуулсан мэдээллийг хэрэглэхийг хүссэн аливаа хэрэглэгч уг мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх, саадгүй ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

(b) Төсөв. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг тус бүрт зарцуулах зардлын тооцоог тусгасан байна.

7. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах үүрэг

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах үндсэн үүргийг Монголын МСС-гийн Мониторинг, үнэлгээ хариуцсан захирал хүлээх бөгөөд энэ ажилд МСК-ын Мониторинг, үнэлгээний мэргэжилтнүүд болон эдийн засагчид дэмжлэг үзүүлнэ. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулахдаа голлох талууд тухайлбал, Монголын МСС-гийн удирдлага, асуудал хариуцсан захирлууд, МСК-ын суурин захирал, МСК-ын холбогдох албан тушаалтнууд болон бусад талуудыг оролцуулах шаардлагатай. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг дээрх талууд хамтран боловсруулах хэдий ч МСК болон Монголын МСС-гийн тухайн Төсөл, Үйл ажиллагааг хариуцсан удирдлагууд нь тус тусын хариуцсан Төсөл, Үйл ажиллагааг удирдах, хянахад хэрэглэх явцын болон үр дүнгийн үзүүлэлтүүдийг сонгох ажлыг удирдлага, чиглэлээр хангаж ажиллана.



8. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө, түүнд оруулах өөрчлөлтүүдийг батлах болон хэрэгжүүлэхдээ Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ, холбогдох бусад Нэмэлт гэрээнүүд болон МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлогыг баримтална. Монголын МСС-гаас Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах бол өмнө нь МСК-д танилцуулж, бичгээр зөвшөөрөл авсан байна. Тэрхүү өөрчлөлтийг албажуулан батлахын өмнө МСК-ын дотоодод холбогдох мэргэжилтнүүд хянан үзэж болно.

9. Компакт гэрээний дараах мониторинг, үнэлгээ

Компакт гэрээний төгсгөлд хийх Хөтөлбөрийн хаалтын төлөвлөгөөний хүрээнд, МСК болон Монголын МСС хамтран энэхүү Компакт гэрээг хэрэгжүүлснээр бий болж, цаашид үргэлжилсээр байх үр өгөөжийг хэмжих зорилгоор хийх Компакт гэрээний дараах Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулна. Уг төлөвлөгөөнд цаашид хийгдэх мониторинг, үнэлгээний ажлуудыг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх албан тушаалтан, байгууллагыг заахын зэрэгцээ энэ ажилд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөсөн байна. Компакт гэрээний дараах Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг Мониторинг, үнэлгээний үндсэн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулна.

Хүснэгт 1: Үзүүлэлтүүд

Дараах хүснэгтэд Төслийн логик уялдаанд багтсан үрдүн тус бүртэй холбогдох мониторинг, үнэлгээний үзүүлэлтүүдийг урьдчилсан байдлаар жагсаасан болно. Жилд дор хаяж нэг удаа тайлагнах гол үзүүлэлтүүдийг улирлын мониторингийн тайланд тусгах бол тусгайлсан судалгаагаар гарч ирэх, эсвэл гаргахад урт хугацаа шаардагдах үзүүлэлтүүдийг үнэлгээний тайлангуудад тусгана.



Хүснэгт 1: Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл						
Үр дүн	Нэмэгдсэн усыг Улаанбаатар хотын унд ахуйн хэрэглэгчид хэрэглэсэн	Улаанбаатар хотын гэр хороолол болон орон сууцны оршин суугчдын хэрэглэсэн нийт ус	Сая м ³	Утга: 40.92 Жил: 2018	Утга: 47,61	Үгүй
Үр дүн	Нэмэгдсэн усыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглагчид хэрэглэсэн	Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэглэсэн нийт ус /худалдаа, ус ундааны үйлдвэрлэл, ноос ноолуур арьс ширний үйлдвэрийн хэрэглээ гэсэн задаргаатайгаар/	Сая м ³	Утга: 21.52 Жил: 2018	Утга: 25.05	Үгүй
Үр дүн	Зорилт: Нэмэгдэхээр тооцоолсон эрэлт хангагдсан	Тооцоолсон эрэлтээс (Эрсдэл /Төсөөлөл С) бусад эх үүсвэрүүдээс олборлох усны хэмжээг хассан дүн нь МСК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулах худгуудаас олборлох усны хэмжээнээс давахгүй байх	Сая м ³	Утга: 0 Жил: Тодорхойлох боломжгүй Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 1.634631	Тийм
Эрсдэл/Төсөөлөл	Эрсдэл /Төсөөлөл С: Усны бодит эрэлт тооцоолсон эрэлттэй тохирох	Улаанбаатар хотын усны тооцоолсон эрэлт (Айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, эрчим хүч үйлдвэрлэл)	Сая м ³	Утга: 84.406880 Жил: 2018	Утга: 93.387747	Тийм



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Эрсдэл / Төсөөлөл	Эрсдэл / Төсөөлөл В: Олборлосон ус алдагдахгүй байх (Орлого болоогүй ус)	УСУГ-ын систем дэх техникийн усны алдагдал	%	Утга: 14% Жил: 2018	Утга: 14%	Тийм
Үр дүн	Улаанбаатар хотын усны нийлүүлэлтийн өсөлт	УСУГ болон хувийн худгуудыг оруулаад Улаанбаатар хотын ус хангамжийн систем дэх усны нийт нийлүүлэлт (худгуудаас олборлож байгаа нийт усны хэмжээ)	Сая м ³	Утга: 84.406880 Жил: 2018	Утга: 88.334631	Тийм
Үр дүн	Эрсдэл / Төсөөлөл А: Төслөөр байгуулагдахаас бусад эх үүсвэрээс нийлүүлэх ус тооцоолсон түвшнээс хэтрэхгүй байх	УСУГ болон хувийн худгуудыг оруулаад Төслөөр байгуулагдахаас бусад эх үүсвэрийн нийт хүчин чадал (олборлож байгаа усны хэмжээ биш)	Сая м ³	Утга: 86.700000 Жил: 2018	Утга: 86.700000	Тийм
Үр дүн	МСК-ын хөрөнгө оруулалтаар байгуулсан эх үүсвэрээс олборлож байгаа усны хэмжээ	МСК-ын хөрөнгө оруулалтаар байгуулсан буюу шинэчилж сайжруулсан худгуудаас олборлож байгаа усны хэмжээ	Сая м ³	Утга: 0 Жил: Тодорхойлох боломжгүй Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 1.634631	Тийм
Үйл ажиллагаа 1: Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах						
Гарц	Усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх байгууламж	Усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх байгууламжийн барилга угсралт	Огноо	Утга: Тодорхойлох боломжгүй Жил: Тодорхойлох боломжгүй Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 5 дахь жилд Жил: Тодорхойлох боломжгүй Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Тийм



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Гарц	Гүний худгууд	МСК-ын хөрөнгө оруулалтаар байгуулсан гүний худгуудын хүчин чадал (жилд олборлох усны хэмжээ)	Сая м ³	Утга: 0 Жил: 2018 Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 50 (Биокомбинат= 25; Шувуун = 25)	Тийм
Үйл ажиллагаа 2: Хаягдал ус дахин боловсруулах						
Үр дүн	Унд ахуйн хэрэглээнд зориулан чөлөөлөгдсөн гүний ус	Дахин боловсруулсан ус ашигласнаар ДЦС-уудын хэрэглээнээс чөлөөлөгдөж УСУГ-т ирж байгаа нийт усны хэмжээ	Сая м ³	Утга: 0 Жил: 2018 Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 14.6	Тийм
Үр дүн	ДЦС-3 болон ДЦС-4-д үйлдвэрийн зориулалтаар нийлүүлсэн дахин боловсруулсан ус	ДЦС-уудад нийлүүлсэн дахин боловсруулсан нийт усны хэмжээ	Сая м ³	Утга: 0 Жил: 2018 Эх сурвалж: Тодорхойлох боломжгүй	Утга: 14.6	Тийм
Эрсдэл / Төсөөлөл	Эрсдэл / Төсөөлөл E: ДЦС-ууд ашиглаж байгаа худгуудаа УСУГ-т шилжүүлж өгнө	ДЦС-ууд ашиглаж байгаа худгуудаа УСУГ-ын харьяанд шилжүүлнэ	Огноо	Тодорхойгүй	Жил 10	Тийм
Эрсдэл / Төсөөлөл	Эрсдэл / Төсөөлөл D: ДЦС-уудын худгуудыг УСУГ ашиглах холболтууд хийгдэнэ	ДЦС-уудын худгуудыг УСУГ ашиглах холболтууд хийгдэнэ	Огноо	Тодорхойгүй	Жил 10	Тийм
Гарц	Ус дахин боловсруулах үйлдвэр, дагалдах дэд бүтэц	Ус дахин боловсруулах үйлдвэр болон дагалдах дэд бүтцийн хүчин чадал	м ³ /хоног	Утга: 0 Жил: 2018 Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: 50,000	Тийм



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Үйл ажиллагаа 3: Тогтвортой байдал						
Үр дүн	УСУГ-ын худгуудын хүчин чадлын жил тутмын доройтол буурсан	УСУГ-ын худгийн хүчин чадлын жил тутам буурах хувь хэмжээ	%	Утга: 1.21% Жил: 2018	Утга: 2%	Тийм
Үр дүн	Төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийгдсэн	Төлөвлөсөн засвар үйлчилгээнүүдээс бодитоор хийгдсэн хувь хэмжээ	%	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: 100%	Тийм
Үр дүн	Засвар үйлчилгээ, үйл ажиллагааны зардал нөхөх байдал сайжирсан	Засвар үйлчилгээ, үйл ажиллагааны зардлын нөхөгдсөн (үйл ажиллагааны орлого, тариф зэргээс) хувь хэмжээ (Засвар үйлчилгээ нь тоног төхөөрөмжийг шинэчлэн солих зардлыг мөн тусгасан гэж үзсэн. Тухайлбал: худгийн мотор гэх мэт.)	%	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: 100%	Тийм
Дэд үйл ажиллагаа 3.1: Зардал нөхөхөд чиглэсэн үйл ажиллагаа						
Үр дүн	Зардал туссан тарифыг тогтоож, хэрэгжүүлсэн	Тарифын орлого нь УСУГ-ын засвар үйлчилгээ, үйл ажиллагаа болон элэгдлийн зардлыг нөхөж байгаа эсэх	Огноо	Тодорхойгүй	Утга: 6 дахь жил	Тийм
Гарц	Төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа	Судалгаа хийгдэж дууссан байх	Огноо	Тодорхойгүй	Утга: Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход	Тийм
Гарц	Тарифын төсөөлөл, хувилбарууд	Тарифын төсөөлөл, хувилбаруудыг санал болгосон байдал	Огноо	Тодорхойгүй	Утга: Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход	Тийм



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Дэд-үйл ажиллагаа 3.2: Гэр хорооллын ус хангамжийн зардлыг бууруулах						
Үр дүн	Гэр хороолол дахь УСУГ-ын ус түгээх худгуудын үйл ажиллагааны зардал буурах	Гэр хорооллын ус хангамжийн дэд бүтцэд МСК-аас хөрөнгө оруулсны үр дүнд УСУГ-т бий болох зардлын хэмнэлт	Төгрөг (MNT)	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	Үгүй
Үр дүн	УСУГ-ын нөхөгдөхгүй байгаа зардал буурах	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Үр дүн	Зардлыг бууруулахад холбогдох талуудын уялдаа, хамтын ажиллагаа	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Ус түгээх худгуудыг сайжруулсан	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Зардал бууруулах зорилгоор салбар хоорондын зохицуулалт хийх, шийдвэр гаргах төлөвлөгөө	Тодорхойгүй	Огноо	Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Дэд үйл ажиллагаа 3.3: Ус ашиглалтын үйл ажиллагааг дэмжих						
Үр дүн	УСУГ-ын боловсон хүчний засвар үйлчилгээ хийх, үйл ажиллагаагаа явуулах үр чадвар дээшилсэн	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Үр дүн	УСУГ-ын сул талуудыг (Aquarating ашиглан тогтоосон) сайжруулах арга хэмжээ авсан	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Үр дүн	УСУГ-ын боловсон хүчний өгөгдөл, тоон мэдээлэл ашиглах, дүн шинжилгээ хийх чадвар сайжирсан	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Туршлага солилцох хамтын ажиллагааны түншлэлийн хөтөлбөр (Твиннинг) зохион байгуулагдсан сургалт	Танилцах аяллын тоо (Хагас жил тутамд, Хамтрагч байгууллагаас УСУГ руу, мөн УСУГ-аас хамтрагч байгууллага руу)	Тоо	0	Тодорхойгүй	Тийм
Гарц	Хөрөнгийн удирдлагыг сайжруулах техникийн туслалцаа	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Хэрэглэгчдийн өгөгдөл тоон мэдээллийг ашиглах, түүнд дүн шинжилгээ хийхэд үзүүлэх техникийн туслалцаа	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Дэд үйл ажиллагаа 3.4: Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилсан цэвэрлэх, бохирдлыг хянах						
Үр дүн	ТЦБ-аас гарч байгаа ус стандартыг хангах	MNS 4943-2015 стандартыг ТЦБ хангаж байгаа эсэх	Огноо	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	5 дахь жил	Тийм



Үзүүлэлтийн төрөл	Үр дүн	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Суурь утга	Компакт гэрээгээр хүрэх зорилтот түвшин (2023)	ҮХХ-ийн үзүүлэлт эсэх (Тийм /Үгүй)
Гарц	Үйлдвэрийн усны бохирдлыг хянах, холбогдох шаардлагуудын хэрэгжилтийг хангахад үзүүлэх техникийн туслалцаа	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Дэд үйл ажиллагаа 3.5: Олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, зан үйл өөрчлөх						
Үр дүн	Усны нөөцийн үнэ цэнийн талаарх олон нийтийн ойлголт сайжирсан	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	
Гарц	Зан үйлийг өөрчлөх үйл ажиллагаанууд	Тодорхойгүй		Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй Эх сурвалж: Тодорхойгүй	Утга: Тодорхойгүй Жил: Тодорхойгүй	

IV ХАВСРАЛТ

КОМПАКТ ГЭРЭЭНИЙ УРЬДЧИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИГДАХ БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийг зарцуулах тухай бүрт (“Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн зарцуулалт” гэх) IV Хавсралтад заасан урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хангасан байна. Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурснаар Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн зарцуулалтыг Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээний холбогдох заалтуудаар зохицуулах бөгөөд энэхүү IV Хавсралтад заасан нөхцөлүүд үйлчилсэн хэвээр байна.



1. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн эхний зарцуулалтад тавигдах Урьдчилсан болзолт нөхцөлүүд.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн эхний зарцуулалт хийхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) Засгийн газар (эсхүл Монголын МСС)-аас дараах баримт бичгийг МСК-д хүргүүлсэн байх. Үүнд:

(i) МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан Санхүүгийн хариуцлагын түр төлөвлөгөө;

(ii) МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.

2. Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн бүх зарцуулалт (Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн эхний зарцуулалтыг оролцуулан)-д тавигдах Урьдчилсан болзолт нөхцөлүүд

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн зарцуулалтыг хийхэд дараах шаардлагыг хангасан байна. Эдгээр нь:

(а) Засгийн газар (эсхүл Монголын МСС)-аас агуулга, хэлбэрийн хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан дараах баримт бичгийг хүргүүлсэн байх. Үүнд:

(i) Тайлан гаргах зааварчилгааны дагуу бэлдсэн Зарцуулалтын хүсэлтийг тухайн Зарцуулалтын хугацаанд хамаарах Тайлангийн хамт;

(ii) МСК-аас ирүүлсэн загварын дагуу Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлтийг хүргүүлсэн өдрөөр огноолсон Засгийн газрын (эсхүл Монголын МСС) баталгаа;

(iii) Санхүүгийн төлөөлөгч томилогдсон бол Санхүүгийн төлөөлөгчийн Зарцуулалтын баталгаа; болон

(iv) Худалдан авах ажиллагааны төлөөлөгч томилогдсон бол Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн Зарцуулалтын баталгаа.

(b) Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийг банкны данс руу шилжүүлэх бол (i) тухайн банкт хийсэн хүчин төгөлдөр гэрээ болон (ii) Зөвшөөрөл бүхий данс нээлгэсэн баримт бичгүүдийг МСК-д хүргүүлсэн байх,

(c) Засгийн газар Санхүүгийн төлөөлөгчтэй байгуулсан гэрээний үнэн зөв, бүрэн хувийг МСК-д хүргүүлэх, улмаар Санхүүгийн төлөөлөгч үйл ажиллагаагаа эхлэх хүртэл МСК-аас зөвшөөрсөн байгууллага эсхүл хувь хүнийг Санхүүгийн төлөөлөгчөөр томилсон байх,

(d) Засгийн газар Худалдан авах ажиллагааны төлөөлөгчтэй байгуулсан гэрээний үнэн зөв, бүрэн хувийг МСК-д хүргүүлэх, улмаар Худалдан авах ажиллагааны төлөөлөгч үйл ажиллагаагаа эхлэх хүртэл МСК-аас зөвшөөрсөн байгууллага эсхүл хувь хүнийг Худалдан авах ажиллагааны төлөөлөгчөөр томилсон байх,

(e) МСК нь (i) Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийг зарцуулж буй үйл ажиллагаа нь Компакт гэрээний хэрэгжилтийг хангахад шаардлагатай, хэрэгжүүлэхүйц, эсхүл Компакт гэрээний хэрэгжилтийг хангах зорилготой нийцэж байх, түүнчлэн холбогдох аливаа хууль тогтоомжийг зөрчихгүй байх, (ii) Засгийн газар, Монголын МСС болон холбогдох төрийн байгууллагуудаас энэхүү Компакт гэрээ болон холбогдох Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа үл биелүүлээгүй буюу зөрчөөгүй байх, (iii) МСК-аас хүссэн санхүүжилтийг ашиглах, зарцуулахдаа энэхүү Компакт гэрээний 2.7 дахь Хэсэгт заасан МСК-ын санхүүжилтэд тавигдах аливаа хязгаарлалт болон холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй бөгөөд цаашид зөрчихгүй байх, (iv) холбогдох Зарцуулалтыг хийх хугацаанаас өмнөх 90 хоногийн дотор МСК-ын хөрөнгөөр төлсөн аливаа Татварын үнийн дүнг Засгийн газраас энэхүү Компакт гэрээний 2.8(с) дэх Хэсгийн дагуу бүхэлд нь буцаан төлсөн байх, (v) Засгийн газар хүлээсэн төлбөрийн бүх үүрэг хариуцлага, түүний дотор даатгал, нөхөн төлбөр, татварын болон бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн бөгөөд шаардлагатай бүх эх үүсвэрийг энэхүү Компакт гэрээ болон холбогдох Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу хариуцан гаргах гэсэн нөхцөлүүд хангалттай биелсэн гэж дангаараа үзсэн байх,

(f) Энэхүү Компакт гэрээний 7 дахь хэсгийн дагуу Компакт гэрээ хүчин төгөлдөр болсны дараа хийгдэх Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн аливаа зарцуулалтыг хийхэд (i) Техникийн аливаа зөвлөх (Монголын МСС-гаас томилсон байгаль орчны аудитын байгууллагыг



оролцуулан)-үүд нь хамгийн сүүлийн Санхүүжилтийн хүсэлт гаргаснаас хойшх хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаарх тайланг хэлбэр, агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, МСК-д хүргүүлсэн, (ii) Хэрэгжилтийн төлөвлөгөөтэй холбоотой баримт бичгүүд болон Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөг хэлбэр, агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн эцсийн байдлаар шинэчилсэн бөгөөд Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн тухайн Зарцуулалтад хамаарах аливаа Үйл ажиллагааны Хэрэгжилтийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэгт МСК-ын шаардлагыг хангахуйц ахиц дэвшил гарсан, (iii) Төсөл эсхүл холбогдох Үйл ажиллагааны Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон Нийгэм, жендэрийн асуудлыг тусгах төлөвлөгөөний чиглэлээр МСК-ын шаардлагад нийцэхүйц ахиц тус тус гарсан, түүнчлэн Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон Нийгэм, жендэрийн асуудлыг тусгах төлөвлөгөөнд багтсан шаардлагууд (эдгээр төлөвлөгөөнд туссан Компакт гэрээний санхүүжилтийн зарцуулалтын тухайн хугацаанд хамаарах зорилтот түвшин, тайлангийн шаардлагууд оролцуулан)-ыг бодитойгоор хангасан, (iv) Энэхүү Компакт гэрээ болон Аудитын төлөвлөгөөний дагуу хүргүүлсэн сүүлийн хоёр улирал (эсхүл Аудитын төлөвлөгөөнд шаардлага болгосон бусад хугацаа)-ын санхүүгийн аудитын тайланд сөрөг дүгнэлт байхгүй байх, (v) МСК нь Монголын МСС-гийн Санхүүжилтийн зарцуулалтын маягт, Санхүүгийн асуудал хариуцсан төлөөлөгчийн зарцуулалтын баталгаа, Худалдан авах ажиллагаа хариуцсан төлөөлөгчийн баталгаанд хамаарах аливаа асуудлыг баталгаажуулахгүй гэж үзэх үндэслэлгүй, (vi) Монголын МСС-гийн аливаа ажилтан, мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл өөрийн хүсэлтээр гарснаас үүдэн орон тоо сул байгаа тохиолдолд уг орон тоонд авах хүнийг Монголын МСС-гийн зүгээс идэвхтэй хайж байгаа гэсэн нөхцөлүүд хангалттай биелсэн хэмээн МСК дангаараа үзсэн байх,

(g) Энэхүү Компакт гэрээний 5.1 дэх хэсгийн дагуу энэхүү Компакт гэрээ болон МСК-ын санхүүжилтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох эсхүл хүчингүй болгох үндэслэл болохуйц үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдал, үйл явдал тохиосон хэмээн МСК нь дангаараа тодорхойлоогүй байх зэрэг болно.

V ХАВСРАЛТ КОМПАКТ ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХОД ТАВИГДАХ НЭМЭЛТ НӨХЦӨЛҮҮД

Энэхүү Компакт гэрээ хүчин төгөлдөр болохын өмнө дараах нэмэлт нөхцөлүүдийг хангасан байна. Үүнд:

(a) Засгийн газар нь (i) УСУГ-ын санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан урт хугацааны өр төлбөрөөс уг байгууллагыг чөлөөлсөн байх, (ii) Улаанбаатар хот, түүний дотор гэр хорооллын ус хангамж, хаягдал ус татан зайлуулах үйлчилгээ, цэвэршүүлэх системийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ болон элэгдэл хорогдлын зардлыг 2023 оны эцэс гэхэд УСУГ-ын цэвэр, бохир усны тариф, хураамжийн орлогоос (болон шаардлагатай бол шууд татаасаар) бүрэн нөхдөг болсон байх Нарийвчилсан төлөвлөгөө (“**Зардал нөхөх төлөвлөгөө**” гэх)-г МСК-ын шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулж баталсан байх. Засгийн газраас цаашид УСУГ-т урт хугацааны өрийг үүсгэх тохиолдолд Зардал нөхөх төлөвлөгөөнд тухайн өрийг хэрхэн барагдуулах арга замыг тусгана.

(b) Засгийн газар нь шинэ Төв цэвэрлэх байгууламж ашиглалтад орохоос өмнө одоо үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж руу үйлдвэр, аж ахуйн газруудаас нийлүүлж буй хаягдал ус дахь химийн бодисын агууламжийг 2013 оны түвшин, эсхүл түүнээс бага хэмжээнд хүргэх зорилго бүхий Нарийвчилсан төлөвлөгөөг МСК-ын шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулж баталсан байх (“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө” гэх).

(c) Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барихтай холбоотой зардлыг санхүүжүүлэх Санхүүжилтийн гэрээг Засгийн газар байгуулсан байх бөгөөд МСК-д (i) уг Санхүүжилтийн гэрээний хүчин төгөлдөр хувийг бүрэн эхээр нь, эсхүл (ii) уг Санхүүжилтийн гэрээнд туссан нөхцөлүүдийн талаарх дэлгэрэнгүй тоймыг хүргүүлсэн байх.

(d) Засгийн газар нь шинэ Төв цэвэрлэх байгууламж Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жилийн дотор ашиглалтад орно гэдгийг нотолсон ажлын нарийвчилсан төлөвлөгөө эсхүл барилга угсралтын ажлын цаг хугацааны хуваарийг МСК-д хүргүүлсэн байх.

(e) Засгийн газар нь шинэ Төв цэвэрлэх байгууламжийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахаар шалгарсан гүйцэтгэгчийн боловсруулсан нарийвчилсан зураг төсөл, үйл ажиллагааны загвар тооцооллыг МСК-д хүргүүлсэн байх.

(f) Төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажил эхэлсэн талаарх нотлох баримтыг Засгийн газраас МСК-д хүргүүлсэн байх.

VI ХАВСРАЛТ НЭР ТОМЬЁО

Үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нэмэлт төлөөлөгч-4.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хавсралт-6.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитын зааварчилгаа - 3.8(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитын төлөвлөгөө - 3.8(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Банк-Монголын МСК-гийн Зөвшөөрөл бүхий дансыг нээхээр МСК-аас зөвшөөрсөн санхүүгийн байгууллагыг хэлнэ.

Банктай хийсэн хүчин төгөлдөр гэрээ – Хэлбэр болон агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, гарын үсэг зурах эрх, нэвтрэх эрх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг заалтууд болон Монголын МСС-гийн Зөвшөөрөл бүхий данстай холбоотой бусад заалтуудыг агуулсан, Монголын МСС болон Банкны хооронд байгуулсан гэрээг хэлнэ.

Суурь утга-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Удирдах зөвлөл-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зардал-үр өгөөжийн шинжилгээ-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Гэрээний хаалтын тайлан-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн тухай хэлэлцээр-3.2(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

ДЦС-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

ДЦС-3 - I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

ДЦС-4 - I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нийтлэг үзүүлэлтүүд-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Гэрээ-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт-2.2(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн зарцуулалт-IV Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлт- Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтэд хамаарах Зарцуулалтын хүсэлтийг хэлнэ.

Компакт гэрээний зорилго-1.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний тайлан, бүртгэл-3.7(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээ хэрэгжих хугацаа-3.7(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зардал нөхөх төлөвлөгөө-V Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитад хамрагдах үүрэг бүхий нийлүүлэгчид-Аудитын зааварчилгаанд заасан утгыг илэрхийлнэ.

Төв цэвэрлэх байгууламж-I Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөө-Монголын МСС-гаас ирэх жилийн улирал тус бүрээр болон Компакт гэрээ хэрэгжих үлдсэн хугацаанд жил бүрээр, Тайлан гаргах зааварчилгааны дагуу боловсруулан хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөгөөг хэлэх бөгөөд уг төлөвлөгөөнд Хөтөлбөр (захиргааны зардал мөн орно) болон Төслийн санхүүжилтийн шаардлагуудыг дэд үйл ажиллагааны түвшин хүртэл нарийвчлан задалж, төсөвлөгдсөн болон тухай бүр шаардлагатай хэмжээнд тулгуурлан оруулсан байна.

Зарцуулалт-2.4 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зарцуулалтын хугацаа-Монголын МСС-гаас МСК-д хандан Зарцуулалтын хүсэлт гаргах улирал, эсхүл Монголын МСС болон МСК-ын харилцан тохирсон өөр бусад хугацааг хэлнэ.

Зарцуулалтын хүсэлт-Монголын МСС-гаас МСК-д хандан Хөтөлбөрийн санхүүжилт, эсхүл Компакт гэрээний урьдчилсан санхүүжилт авахаар Тайлан гаргах зааварчилгааны дагуу гаргасан хүсэлтийг хэлнэ.

Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Мэдээллийн чанарын хяналт-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Эдийн засгийн өгөөж-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Үнэлгээ-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн илүүдэл дүн-2.2(с) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Чөлөөлөгдсөн этгээд-IV Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Чөлөөлөгдсөн хувь хүн-IV Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Эцсийн үнэлгээ-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө-МСК-аас зөвшөөрсний дагуу Монголын МСС-аас боловсруулан хэрэгжүүлэх гарын авлагыг хэлэх бөгөөд уг гарын авлагад Монголын МСС-гаас МСК-ын санхүүжилтийг ашиглахад баримтлах санхүүгийн хариуцлагын зарчим, механизм, үйл явцыг, тухайлбал буцалтгүй тусламж олгох, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зэрэг ажиллагааг нээлттэй, шударга, ил тод байдлаар явуулах зэрэг зохицуулалтыг зохих ёсоор оруулсан байна.

Санхүүгийн төлөөлөгч-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн төлөөлөгчийн гэрээ-Хэлбэр болон агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, Монголын МСС болон Санхүүгийн төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээг хэлэх бөгөөд уг гэрээнд



Санхүүгийн төлөөлөгчийн хүлээх үүрэг хариуцлага болон холбогдох бусад зохицуулалтыг оруулсан байна.

Санхүүгийн төлөөлөгчийн зарцуулалтын баталгаа-МСК-аас ирүүлсэн хэлбэрийг баримтлан боловсруулсан Санхүүгийн төлөөлөгчийн баталгааг хэлнэ.

Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зорилгын үзүүлэлт-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Засгийн газар-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Засгийн газрын оруулах хувь хэмжээ-2.6(а) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Буцалтгүй тусламж-3.6(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Татварын ерөнхийн газар-IV Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Хэрэгжүүлэх захидал - 3.5 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хэрэгжилтийн төлөвлөгөө-Хэлбэр болон агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулсан, Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалтыг дэлгэрэнгүй тайлбарласан Хэрэгжилтийн төлөвлөгөөний дөрвөн баримт бичгийг нийтэд нь хэлнэ.

Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичиг-(i) Ажлын төлөвлөгөө, (ii) Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөө, (iii) Аудитын төлөвлөгөө, (iv) Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тус бүрийг хэлнэ.

Хэрэгжүүлэгч байгууллага-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Үзүүлэлт хянах хүснэгт-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Үзүүлэлт-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх болон бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө-IV Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн анхны зарцуулалт-Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн эхний зарцуулалтыг хэлнэ.

Ерөнхий хянан шалгагч-3.7(с) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Оюуны өмч-бүртгэлтэй болон бүртгэлгүй аливаа барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, лого, нэр, барааны нэр, бусад бүх барааны тэмдэгтэй холбоотой эрхийг; бүртгэлтэй болон бүртгэлгүй аливаа зохиогчийн эрх; патент, нээлт, дэлгүүрийн эрх, ноухау, худалдааны нууц, загвар дизайн,

зураг, урлагийн бүтээл, төлөвлөгөө, хэвлэмэл бүтээл, гарын авлага, компьютерын файл, програм хангамж, хэвлэгдсэн материал, каталоги, техникийн үзүүлэлт, тухайн байгууллагын эзэмшилд буй технологи бөгөөд эдгээртэй төстэй мэдээлэл; МСК-аас бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж бүртгүүлсэн, түүнчлэн бүртгүүлэхээр өргөдөл гаргасан дээр дурдсан бүхий л төрлийн оюуны өмчийг хэлнэ.

Мониторинг, үнэлгээ-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Удирдлагын баг-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Мянганы сорилтын тухай хууль-2.2(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Монголын Мянганы сорилтын сан-3.2(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Мянганы сорилтын корпорац-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

МСК-ын Байгаль орчны зааварчилгаа-2.7(c) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

МСК-ын санхүүжилт-2.3 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

МСК-ын Жендэрийн бодлого - МСК-ын Жендэрийн бодлого, түүнтэй холбоотой бүх баримт бичиг, зааварчилгааг хамруулна.

МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлого-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

МСК-ын Хөтөлбөрийн хаалтын зааварчилгаа-МСК-ын Хөтөлбөрийг хаах зааварчилгаа, түүнтэй холбоотой бүх баримт бичиг, зааварчилгааг хамруулна.

МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа-3.6(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

МСК-ын цахим хуудас-www.mcc.gov хаяг дээр байрлах МСК-ын цахим хуудас.

Сая шоо метр-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Монгол Улс-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Мониторингийн бүрэлдэхүүн хэсэг-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөний хураангуй-II Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Үндэсний ажлын алба-I Хавсралтын А дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.



Үйл ажиллагаа болон засвар үйлчилгээ-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Тал болон талууд-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хуваарьт тайлан-Монголын МСС-аас хэлбэр, агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, Тайлан гаргах зааварчилгаанд зааснаар тогтмол хуваарийн дагуу МСК-д хүргүүлэх тайлан, мэдээллийг хэлнэ.

Зөвшөөрөл бүхий данс-2.4. дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Бохирдуулагч төлөх зарчим - 8.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Үндсэн төлөөлөгч-4.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөөлөгч-I Хавсралтын С дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гэрээ-Хэлбэр болон агуулгын хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, Монголын МСС болон Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээг хэлэх бөгөөд уг гэрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хянах зэрэгтэй холбоотой Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн хүлээх үүрэг хариуцлага болон холбогдох бусад зохицуулалтыг оруулсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн Зарцуулалтын гэрчилгээ -МСК-аас ирүүлсэн хэлбэрийг баримтлан боловсруулсан Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн баталгааг хэлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-Компакт гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, ажил, зөвлөх болон бусад үйлчилгээг худалдан авахад зориулан Монголын МСС-гаас боловсруулсан төлөвлөгөөг хэлнэ.

Хөтөлбөр-Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ

Хөтөлбөрийн өмч хөрөнгө-МСК-аас (шууд эсхүл шууд бусаар) бүхэлд нь эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж, худалдан авсан аливаа үндсэн хөрөнгө, бараа, (бодит, биет эсхүл биет бус) өмчийг хамааруулан ойлгоно.

Хөтөлбөрийн санхүүжилт-2.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ

Хөтөлбөрийн зааварчилгаа-Аудитын зааварчилгаа, МСК-ын Байгаль орчны зааварчилгаа, МСК-ын Хариуцлагатай этгээд болон Хэрэгжилтийн бүтцийн зааварчилгаа, МСК-ын Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа, Тайлан гаргах зааварчилгаа, МСК-ын Мониторинг, үнэлгээний бодлого, Компакт гэрээний хэрэгжилтэд оролцох Засгийн газрын байгууллагын зардлын зарчмууд, МСК-ын Хөтөлбөрийн хаалтын зааварчилгаа, МСК-ын Жендэрийн бодлого, МСК-ын Жендэрийн асуудлыг төсөл, хөтөлбөрт тусгах зааварчилгаа, МСК-ын Эдийн засгийн болон үр өгөөж хүртэгчийн шинжилгээний

зааварчилгаа, МСК-ын Олон улсын барааны тэмдэгтийн стандарт, МСК-ын Буцалтгүй тусламж хүлээн авах орны оруулах хувь хэмжээний тухай зааварчилгаа, түүнчлэн МСК-ын санхүүжүүлттэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулан гаргаж, МСК-ын цахим хуудсанд байршуулсан бусад бодлого, зааварчилгаа, гарын авлага зэргийг хамтад нь ойлгоно.

Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ-3.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Төсөл-1.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Төслийн зорилт-1.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нийлүүлэгч гэж (а) энэхүү Компакт гэрээний хэрэгжилтийн явцад МСК-ын санхүүжилт эсхүл Хөтөлбөртэй холбоотой бусад хөрөнгийг хүлээн авч, ашиглаж буй аливаа Засгийн газрын байгууллага эсхүл (b) Гэрээний хугацаанд МСК-аас нийтдээ 50,000 ам.доллар бөгөөд түүнээс дээш хэмжээний санхүүжилт авсан (Засгийн газрын харьяа байгууллагын ажилтны авч буй цалин эсвэл нөхөн төлбөрийг оруулахгүй) гуравдагч этгээдийг хэлнэ.

Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Тайлан гаргах зааварчилгаа-МСК-ын Хариуцсан этгээд зарцуулалтын хүсэлт болон үйл ажиллагааны багц тайлангаа улирал бүрээр гарган хүргүүлэх зааварчилгааг ойлгоно.

Нийгэм, жендерийн асуудлыг тусгах төлөвлөгөө-I Хавсралтын А дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нэмэлт гэрээ-Энэхүү Компакт гэрээний хэрэгжилтийг цаашид хангахтай холбоотой аливаа санхүүжилт, хэрэгжүүлэх арга хэлбэр, зохицуулалтыг Компакт гэрээнд нийцүүлэн нарийвчлан тусгасан (а) Засгийн газар (эсхүл Монголын МСС, Засгийн газрын харьяа байгууллага) болон МСК-ын хооронд (Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээг оролцуулан түүгээр хязгаарлагдахгүйгээр) байгуулсан аливаа хэлэлцээр, эсхүл (b) нэг талаас МСК болон/эсхүл Засгийн газар (эсвэл Монголын МСС болон Засгийн газрын харьяа байгууллага) нөгөө талаас Нийлүүлэгч, аливаа гуравдагч этгээдийн хооронд байгуулсан аливаа хэлэлцээрийг хэлнэ.

Зорилтот түвшин-III Хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

Татвар-2.8(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Америкийн Нэгдсэн Улсын доллар-Америкийн Нэгдсэн Улсын албан ёсны мөнгөн тэмдэгт.

Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.



Ус сувгийн удирдах газар-8.3 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа-I Хавсралтад В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа-I Хавсралтын В дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл -8.3 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.75

Индекс: 200003